МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Нэгдсэн үндэстний гудамж 5,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 15 53, Факс: 32 86 34,
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2025.07.29 № 01/2505

танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Д.АМАРБАЯСГАЛАН, МОНГОЛ
УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
С.МАГНАЙСҮРЭН, САНГИЙН
САЙД Б.ЖАВХЛАН ТАНАА

2026 оны төсвийн төсөлд
санал хүргүүлэх тухай

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн саналыг Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын дагуу шинэчлэн боловсруулж хавсралтаар хүргүүлж байна.

Төсвийн төслийг хянан үзэж, нэгдсэн төсвийн төсөлд тусгаж өгнө үү.

Хавсралт...хуудастай.

Хүндэтгэсэн,

Т.АУБАКИР

АТА12944 9132155 9024070603

D: 2025 on 08 sar A4

Боловсруулсан
Хянасан
Хувь 2

М.Энх-Отгон
Ж.Энхтөр

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөлөл, нэгдсэн танилцуулга, холбогдох маягт, судалгаа			
1.1. Төсвийн саналын маягт	ТМ-01	Салбарын 2026 оны урсгал төсвийн төслийн санал	
	НМ-01	ТЕЗ-ийн харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлогын санал	
	НМ-02	ТЕЗ-ийн төсвийн урсгал зарлагын саналын товчоо	
	НМ-03	ТЕЗ-ийн эргэж төлөгдөх цэвэр зээлийн санал	
	НМ-04	ТЕЗ-ийн шинээр ашиглалтад орох хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй холбогдон гарах урсгал зардлын тооцоо	
	НМ-06 (УТ) НМ-06а (УТ)	Нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдагчдын судалгаа	
	НМ-07 НМ-07а НМ-07б НМ-07в	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн судалгаа	
	НМ-08	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх мөнгөн тэтгэмж авах албан хаагчийн судалгаа	
	НМ-09	ТЕЗ-ийн Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн санал	
	НМ-11а НМ-11б	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон бараа үйлчилгээний бусад зардал эдийн засгийн ангилалд тусгах зардлын задаргаа	
	НМ-12	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын судалгаа	
Хавсралт 2. Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөлөл, нэгдсэн танилцуулга, холбогдох маягт, судалгаа			
	Төсвийн нэгтгэл		
	Нэгдсэн танилцуулга		
Хавсралт 3.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, түүний шалгуур үзүүлэлт		
Хавсралт 4.	Хуримтлалын сангийн 2026 оны Төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөлөл		
Хавсралт 5.	Төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотой 2026 оны үлсын төсвийн төсөлд тусгах санал		
Хавсралт 6.	Төсөв дагах хууль, журмын төсөл		
	Хуулийн төсөл -1		
	УИХ-ын тогтоолын төсөл 1		
	Засгийн гарын тогтоолын төсөл -1		

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайдын 2025 ны 07 дугаар
сарын 29-ны өдрийн 01/2505 дугаар
албан бичгийн нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН САНАЛ

Улаанбаатар
2025

АГУУЛГА

НЭГ. ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН САНАЛ 3-9

1.1. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГУУДЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН САНАЛ 10-25

1.1.1. Нийгмийн халамжийн сан.....

1.1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан.....

1.1.3 Хүүхдийн төлөө сан.....

1.2. ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ХАРЬЯА ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН САНАЛ 26-40

1.2.1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, харьяа байгууллагууд

1.2.2 Нийгмийн даатгалын ерөнхий газар, харьяа байгууллагууд.

1.2.3. Гэр бүлийн хөгжил, хамгаллын ерөнхий газар, харьяа байгууллагууд

1.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газар, харьяа байгууллагууд

1.2.5. Хөдөлмөр нийгмийн хамгаллын яам

1.2.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв

1.2.7. Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сургалт, судалгааны институт

ХОЁР. САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН САНАЛ 41-44

ГУРАВ. ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН 2026 ОНЫ ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА 45-47

НЭГ. ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2026 оны төсвийн хязгаарын саналд тусгасан хөрөнгө нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, энэ чиглэлээр салбар хоорондын зохицуулалт хийх, цалин хөлс, хөдөлмөрийн харилцааны оновчтой тогтолцоо, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, монгол хүний амьдралын түвшин, чанарыг дээшлүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Түүнчлэн хүн амын хөгжлийг хангах, нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзан хүн амын бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах, салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдэх юм.

Тус салбарт хамаарч байгаа Засгийн газрын тусгай сан болох Нийгмийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Хүүхдийн төлөө сан болон салбарын хэмжээнд шаардлагатай байгаа бусад хөрөнгийг Улсын Их Хурал, Засгийн газар эрх бүхий байгууллагаас батлсан хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичиг, тогтоол, шийдвэр, салбарын бодлого зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэх, шинээр санаачлан хэрэгжүүлэх, салбарын хөрөнгө оруулалтын бодлогыг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулан боловсруулах зэрэгт чиглүүлэн үр дүнтэй, оновчтой төлөвлөж, хуваарилах, зарцуулах замаар тавьсан зорилтоо амжилттай хэрэгжүүлэн ажиллана.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг Монгол Улсын Их Хурлаас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01 дугаар тогтоолоор баталсан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаар болон 2024 оны төсвийн гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, харьяа төсвийн төвлөрүүлэн болон төсвийн шууд захирагч нараас ирүүлсэн саналд үндэслэн нэгтгэн боловсруулж Сангийн сайдаас ирүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн хүрээнд:

- Төсөвт байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, өр төлбөр үүсгэхгүй ажиллах;
- Харьяа байгууллагуудын бүтэц, орон тооны өөрчлөлтөөс шалтгаалан цалин, бусад урсгал зардлыг төсөвт ачаалал нэмэгдүүлэхгүй байх;
- Засгийн газрын тусгай сангуудын бие даасан байдал, үр ашигтай ажиллах боломжийг бүрдүүлэх;
- Төрийн хэмнэлтийн зарчмыг баримтлах;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ач холбогдлоор нь эрэмбэлэн, үр ашигтай хөрөнгө оруулалтыг тусгах зэрэг зарчмыг баримтлан бэлтгэсэн болно.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, тусгай сангуудын тогтвортой байдал болон салбарын хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2026 оны төсвийн зарлагыг Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсөвт **5,462.7 тэрбум** төгрөгөөр тусгуулах төсвийн санал хүргүүлж байна. Үүнд:

- Засгийн газрын тогтоолоор 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01 дугаар тогтоолоор батлагдсан төсвийн хязгаарт багтаан салбарын бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, тусгай сангуудын тогтвортой байдал болон салбарын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах **4,450.0 тэрбум** төгрөгийн зардал;
- Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025-2026 онд баригдаж ашиглалтад орсон барилга, байгууламжтай холбоотой урсгал зардалд шаардлагатай **7.7** тэрбум төгрөг;
- Нийгмийн халамж, нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтөд хамрагдах хүн амын өсөлтөөс шалтгаалсан нэмэлт зардлыг **1,004.9** тэрбум төгрөгөөр тус тус тооцон тусгалаа.

1. Эх үүсвэр:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын төсвийн ерөнхийлөн захирагчаас Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсөвт тусгуулахаар 5,462.7 тэрбум төгрөгийн зардал санхүүжүүлэх эх үүсвэр төлөвлөв.

Хүснэгт 1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2026 оны төсвийн зардал санхүүжүүлэх эх үүсвэрийн товчоо(сая.төг)

Код	Эдийн засгийн ангилал	ГҮЙЦЭТГЭЛ		САНАЛ				ӨӨРЧЛӨЛТ	
		2025 Батлагдсан	2025 ХБГ	2026 Хяз	2026 ТЕЗ санал	2026 ТЕЗ Шинэ ХО урсгал	2026 ТЕЗ Хүн амын өсөлт	2026 хяз 2026 сан	2026 хяз 2026 сан
31	Улсын төсвөөс санхүүжих	4,382,819.7	4,351,871.6	4,303,904.9	4,308,227.0	5,987.1	1,004,944.8	-1.0%	(43,644.6)
310001	Улсын төсвөөс санхүүжих	4,382,819.7	4,351,871.6	4,303,904.9	4,308,227.0	5,987.1	1,004,944.8	-1.0%	(43,644.6)
33	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,035.1	3,035.1	3,035.1	3,035.1	-	-	0.0%	-
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,035.1	3,035.1	3,035.1	3,035.1	-	-	0.0%	-
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	112,916.0	109,638.4	111,752.7	119,894.1	1,722.7	-	9.4%	10,255.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,992.7	58,700.0	58,479.4	40,720.0	1,722.7	-	-30.6%	(17,979.9)
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,126.0	5,589.5	5,491.1	6,546.3	-	-	17.1%	956.8
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	47,797.2	45,349.0	47,782.2	72,627.7	-	-	60.2%	27,278.8
36	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	-	-	-	-	-	-		-
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	-	-	-	-	-	-		-
37	Бусад эх үүсвэр	37,900.0	38,030.3	37,900.0	18,880.0	-	-	-50.4%	(19,150.3)
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	37,900.0	37,900.0	37,900.0	18,880.0	-	-	-50.2%	(19,020.0)
370002	Хэмнэлтээр төсвийн санхүүжилт буурулах	-	130.3	-	-	-	-	-100.0%	(130.3)
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	**4,536,670.8**	**4,502,575.4**	4,456,592.7	**4,450,036.1**	**7,709.8**	1,004,944.8	-42.0%	(52,539.2)

2. Зарлага

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2026 оны төсвийн саналыг нийт 5,462.6 тэрбум төгрөгөөр төлөвлөж байгаа бөгөөд 4,450.0 тэрбум төгрөгийн зардлыг төсвийн хязгаарт багтааж, хүн ам, халамж, нийгмийн даатгалд хамрагдагсдын өсөлтөөс шалтгаалсан нэмэлт зардлыг 1,004.9 тэрбум төгрөгөөр, төсвийн хөрөнгө оруулалтаар

баригдсан шинэ барилга байгууламжийн урсгал зардалд 7.7 тэрбум төгрөгийг нэмэлтээр зарцуулахаар тус тус тооцлоо. Тухайлбал: :

- Хүүхэд хамгааллын зардлыг нийт 20.5 тэрбум төгрөгөөр тооцож байгаа бөгөөд энэхүү зардлын 15.7 тэрбум төгрөгийг төсвийн хязгаарт багтааж, 4.8 тэрбум төгрөгийг үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн тооны өсөлттэй уялдуулан нэмж тооцлоо.
- Нийгмийн халамжийн сангаас 2026 онд олгох хөнгөлөлт, тусламж, үйлчилгээнд 2,639.4 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон бөгөөд 2,518.9 тэрбум төгрөгийг төсвийн хязгаарт багтаан тооцож, 120.4 тэрбум төгрөгийг халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүний тоо, халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн өсөлттэй уялдуулан нэмэлтээр тооцлоо.
- Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсах зардлыг нийт 9.6 тэрбум төгрөгөөр тооцож байгаа бөгөөд энэхүү зардлын 4.9 тэрбум төгрөгийг төсвийн хязгаарт багтааж, 4.6 тэрбум төгрөгийг үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн тооны өсөлттэй уялдуулан нэмж тооцлоо.

Хүснэгт 1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2026 оны төсвийн зарлагын саналын товчоо (сая.төг)

д д	Төсөв захирагч	ГҮЙЦЭТГЭЛ			САНАЛ				ӨӨРЧЛӨЛТ	
		2024 Гүйц	2025 Батлагдсан	2025 ХБГ	2026 Хяз	2026 ТЕЗ санал	2026 ТЕЗ Шинэ ХО урсгал	2026 ТЕЗ Хүн амын өсөлт	2026 хяз 2026 сан	2026 хяз 2026 сан
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА										
1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	61,087.4	56,932.8	55,312.6	59,716.9	56,549.3	-	32,252.4	-5.3%	(3,167.6)
2	Хөдөлмөрийн ажилгүй байдал, эрүүл мэндийн төв	8,706.7	7,579.0	3,436.4	8,375.8	7,934.0	-	-	-5.3%	(441.8)
3	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт	2,664.6	2,515.6	2,032.5	2,786.9	2,876.5	-	-	3.2%	89.6
4	Нийгмийн даатгалын ерөнхий газар	75,089.0	66,210.6	59,637.6	71,947.6	66,519.6	-	-	-7.5%	(5,428.0)
5	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар	83,511.3	72,930.1	71,346.8	87,313.5	79,190.8	798.7	-	-9.3%	(8,122.7)
6	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	102,887.3	83,904.1	57,304.3	90,447.6	81,080.4	5,528.8	20,813.7	-10.4%	(9,367.3)
7	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	39,867.9	29,721.8	18,161.3	34,931.4	31,086.8	1,382.3	4,654.6	-11.0%	(3,844.6)
ТУСГАЙ САН										
1	Нийгмийн даатгалын сан татаас	1,452,499.9	1,452,499.9	1,174,974.0	1,452,499.9	1,452,499.9	-	826,805.0	0.0%	-
2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	130,764.9	129,921.7	84,210.3	126,750.6	117,921.7	-	-	-7.0%	(8,828.9)
3	Нийгмийн халамжийн сан	2,519,052.7	2,518,960.3	2,300,131.6	2,510,761.3	2,518,960.3	-	120,419.2	0.3%	8,199.0
4	Хүүхдийн төлөө сан	8,315.9	8,315.9	260.7	8,315.9	8,315.9			0.0%	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		52,242.3	27,100.9	35,465.3	48,728.1	27,100.9	-	-	-44.4%	(21,627.2)
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН БАГЦ		**4,475,602.5**	**4,399,659.8**	**3,806,960.7**	**4,442,858.5**	**4,393,486.8**	**7,709.8**	**972,692.4**	**-1.1%**	**(49,371.7)**

Нэмж тусгуулах төсвийн зардалд:

а) Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон барилга, байгууламжтай холбоотой урсгал зардалд 7.7 тэрбум төгрөг:
- Архангай, Баян-Өлгий, Сэлэнгэ аймгийн ГБХХГ-т шинээр ашиглалтад орох 3 барилга;
- Налайх дүүргийн 6-р хороо буюу Тэрэлжид Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж 2026 онд ашиглалтад орох хүүхдийн зуслан;
- Өмнөговь аймагт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд ашиглалтад орсон "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийн барилга;

- Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/12 дугаар захирамжаар ХХҮГ-ийн харьяанд шилжүүлсэн “Хүмүүнлэгийн ордон буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв”-ийн барилга, Өмнөговь аймгийн ХХҮГ-ийн дэргэд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж 2025 оны 10 дугаар сард ашиглалтад орох "Өмнөговь аймгийн ХХҮГ-ын офисс, нэг цэгийн үйлчилгээ, ахмадын сувилал"-ын барилга.

Дээрх барилга, байгууламжийг ашиглалтад орсноор 127 ажилтанд холбогдох цалин, нэмэгдэл, урамшуул, НДШ-ийн зардалд 4,685.6 сая төгрөг; байр ашиглалтын зардалд 1,462.0 сая төгрөг; байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангах бараа, үйлчилгээний бусад зардалд 1,562.2 сая төгрөг тус тус нэмэгдсэн;

b) Нийгмийн даатгалын сангийн татаас 826.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн шалтгаан:
   - Тэтгэврийг инфляцийн түвшинтэй уялдуулж нэмэгдүүлэхэд 572.5 тэрбум төгрөг;
   - Төрөөс тэтгэврийг нь хариуцах иргэдийн улсын төсвийн санхүүжилтэд хүн амын өсөлтөөс шалтгаалсан алдагдал 254.3 тэрбум төгрөг тус тус нэмэгдсэн.

c) Нийгмийн халамжийн үйлчилгээний санхүүжилтийг нийт 120.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж буй гол шалтгаан:
   - Нийгмийн халамжийн сангаас олгох хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагдах хүний тоо 70,869 хүнээр нэмэгдсэн өсөлт, зарим төрлийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж хугацаа, давтамж, үнэ, тарифын өөрчлөлтөөс хамаарсан нэмэгдэл 102,250.4 сая төгрөг;
   - Хууль, эрхзүйн өөрчлөлтийн хүрээнд нэмэгдүүлсэн дараах үйлчилгээнд 81355 иргэнд 43.2 тэрбум төгрөг;
     - Цаатан иргэний тэтгэмж: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 42 дугаар зарлиг, Засгийн газрын 2018 оны “Цаатан иргэдийн талаар авах арга хэмжээний тухай” 213 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт цаатан иргэдэд олгох тэтгэмжид шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэхээр тусгасан боловч одоог хүртэл орон нутгийн төсвөөс санхүүжиж байна. Тус тэтгэмжийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаа нь орон нутгийн төсөвт ихээхэн ачаалал үүсгэж байгаа тул Засгийн гарын тогтоолд тусгагдсаны дагуу улсын төсвөөс санхүүжүүлэх талаарх хүсэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газраас удаа дараа албан бичгээр ирүүлсэн. Амьжиргааны доод түвшингийн өсөлттэй уялдан тэтгэмжийн зардал жил бүр өсөж байна. 2026 онд 185 хүүхэд, 248 насанд хүрсэн иргэн, нийт 433 иргэнд 1,827.7 сая төгрөгийн зардлын улсын төсөвт тусгахаар хүргүүлж байна.
     - Хүүхэд хамгааллын тухай хууль 2024 онд шинэчлэн батлагдсантай холбогдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийн 19[1].2. “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлж байгаа гэр бүл, хуулийн этгээдэд олгох хувьсах болон үйлчилгээний зардлыг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ” гэж заасны дагуу нийт 16 хүүхдийн асрамж, халамжийн төвд амьдарч байгаа 550 хүүхдэд хувцас, эм, хоолны зардлыг баталсан нормативын дагуу олгох 4,812.2 сая төгрөг;
     - Нийгмийн халамжийн тэтгэврийг амьжиргааны доод түвшин болон хэрэглээний үнийн өсөлттэй уялдуулан 8 хувиар нэмэгдүүлэх эх үүсвэр 30.618,1 сая төгрөг;
     - Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.11-т “Энэ хуулийн 19.1.1-д заасан үйлчилгээг шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлж болно” гэж заасны дагуу “Батгэрэлт ирээдүй ТББ” байгууллага хүсэлт ирүүлсэн 500.0 сая төгрөг;
     - Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтын төлөө мэдлэг боловсрол, бие сэтгэл, хүч чадлаа дайчлан гавьяа байгуулж Монгол Улсын баатар, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар хэмээх Төрийн эрхэм дээд

цол[1] хүртсэн ахмад настанд насны эрэмбээр тооцож 80-аас дээш настай өндөр настанд 50.0 сая төгрөг, эмэгтэй 55-79, эрэгтэй 60-79 хүртэлх насны ахмад настанд 30.0 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоход 135 иргэнд 5,430.0 сая төгрөг;

- Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 248 дугаар тогтоолоор Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийн 66 дах хэсэгт байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 2-оос дээш насны 3000 хүүхдэд жилд 2 удаа 300,0 мянган төгрөгийн памперс /живх/-ний үнэ олгохоор 1,800.0 сая төгрөг тус тус нэмэгдүүлсэн.

d) Засгийн газрын 2024 оны 143, 237 дугаар тогтоолоор аймаг, дүүргийн ГБХХГ, хэлтэст сум, хороонд томилогдон ажиллаж байгаа 758 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны цалин, нэмэгдэл, урамшууллын зардалд 13,783.9 сая төгрөг;

e) Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрт зарцуулах 7,029.8 тэрбум төгрөг;
   - Хүүхэд харах үйлчилгээнд 2.2 тэрбум төгрөг: 2026 онд хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах хүүхдийн тоог 542 хүүхдээр нэмэгдүүлж 18 аймаг, 7 дүүргийн 2,220 хүүхдийг тус үйлчилгээнд хамруулахаар төсөвлөв.
   - Эрсдэлийн болон НБҮ хийх /нөхцөл байдлын үнэлгээ/ 1.2 тэрбум төгрөг: ЗГ-ын 2026 оны 236 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал", "Хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив"-ын дагуу өмнөх оны статистик мэдээнд үндэслэн холбогдох зардлуудыг тооцон төсөвлөсөн.
   - Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 1.8 тэрбум төгрөг: 2026 онд нийт хүүхдийн 75 хувийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулахаар холбогдох зардлыг төсөвлөв.
   - Хүүхдийн хөгжил, оролцооны зардалд 2.2 тэрбум төгрөг; 2026 оныг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас хүүхдийн хөгжил оролцоог чухалчилж, тэргүүлэх чиглэл болгон ажиллах бөгөөд нийт хүүхдийн 35.5%-ийг тус үйлчилгээнд хамруулж, 451.6 мянган хүүхдэд үйлчилгээ үзүүлэхээр төсөвлөсөн.

f) Монгол Улсын Засгийн газраас 2026 онд Хүний хөгжлийг дэмжих чиглэлийг баримталж хэрэгжүүлэх цогц арга хэмжээнд дараах хөтөлбөрүүдэд нийт 17,560.8 сая төгрөг төлөвлөлөө.

g) Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсах зардлыг нийт 9.6 тэрбум төгрөгөөр тооцож байгаа бөгөөд энэхүү зардлын 4.9 тэрбум төгрөгийг төсвийн хязгаарт багтааж, 4.6 тэрбум төгрөгийг үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн тооны өсөлттэй уялдуулан нэмж тооцлоо.
   - Монгол улсад 0-18 насны 14,609 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа 2,700 гаруй хүүхэд байна. Энэ хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд шаардлагатай байгаа үйлчилгээг тодорхойлон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэн хэрэгжүүлэхээр холбогдох журам удирдамжийг баталсан Энэ үйлчилгээг 2025 онд нийслэлд 8, Баянхонгор аймагт 1 төвийг байгуулан боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хөгжлийн үйлчилгээг үзүүлж байна. Тус үйлчилгээ нь хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тохируулгат орчинд өөрт шаардлагатай

[1] АИХ-ын тэргүүлэгчдийн 1990 оны 148 дугаар зарлигаар Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатар цолыг "ТӨРИЙН ЭРХЭМ ДЭЭД ЦОЛ", Ардын болон Гавьяат цол, төрийн соёрхлыг Төрийн хүндэт цол гэж ялган заагласан байдаг.

боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг гэртээ ойрхон, эцэг эхэд санхүүгийн дарамтгүй авснаар хүүхдийн хөгжилд болон гэр бүлд томоохон дэмжлэг бүхий үр дүнтэй үйлчилгээ болсон. Тиймээс 2026 онд байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх дэмжих төвүүдийг аймаг дүүргүүдэд нэмэгдүүлэх зорилтыг тавиад байна.

Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.1.1.25 - д "Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттайгаар нэвтрүүлж, салбар дундын нийгмийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана." гэж заасан. Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох, тогтоох аргачлалыг олон улсын үйлдлийн чадвар алдалтын системээр /ICF/ тогтоох асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд тусган хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үйлдлийн чадвар алдалтаар нь үнэлснээр нийгмийн халамжийн дэмжлэг тусламжуудыг ялгавартай олгох, туслах хэрэгслийн төрөл хэлбэрийг өргөжүүлэн оновчтой болгох, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр боловсруулж буй бодлогыг оновчтой болгох, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах аргачлал, загварыг боловсруулж, туршиж, нэвтрүүлэх арга хэмжээнд 1,000.2 сая төгрөг;

- МУЗГҮАХ-ын төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн хүрээнд 4,804.5 сая төгрөг төлөвлөснөөс Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 2,206.5 сая төгрөг, хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 400.0 сая төгрөг, гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 1,590.0 сая төгрөг, ахмад насны хөгжил хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 881.0 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн нь 2025 оны батлагдсан төсвөөс 2,015.6 сая төгрөгөөр хязгаараас 3,213.7 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас 2026 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн даатгалын үйлчилгээ, хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого удирдлага, залуучууд болон оюутнууд, хүүхдийн, гэр бүлийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, ахмад настны хөгжил, хамгаалал, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ.

Хүснэгт 2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хэрэгжүүлэх хөтөлбөрийг 2026 онд санхүүжүүлэх төсвийн зарлагын саналын товчоо (сая.төг)

Код	Эдийн засгийн ангилал	ГҮЙЦЭТГЭЛ			САНАЛ				ӨӨРЧЛӨЛТ	
		2024 Гүйц	2025 Батлагдсан	2025 ХБГ	2026 Хяз	2026 ТЕЗ санал	2026 ТЕЗ Шинэ ХО урсгал	2026 ТЕЗ Хүн амын өсөлт	2026 хяз 2026 сан	2026 хяз 2026 сан
71901	Нийгмийн даатгал	1,277,918.9	1,573,645.1	1,569,713.7	1,563,976.7	1,564,285.7	-	837,807.0	-0.3%	(5,428.0)
71902	Нийгмийн халамж	2,376,993.5	2,602,678.6	2,583,194.4	2,579,979.7	2,586,013.2	798.7	120,419.2	0.1%	2,818.8
71903	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого удирдлага	12,428.4	25,457.3	61,081.0	37,886.0	37,446.7	-	555.5	-38.7%	(23,634.2)
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	97,409.2	147,144.2	144,435.6	144,365.9	132,955.9	-	-	-7.9%	(11,479.7)
72103	Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлыг сайжруулах	3,436.4	8,706.7	8,375.8	7,579.0	7,934.0	-	-	-5.3%	(441.8)
72206	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал	20,564.5	54,625.4	36,409.6	30,202.4	31,621.2	1,382.3	6,326.8	-13.2%	(4,788.5)
72207	Хүүхдийн хөгжил, хамгаалал	57,032.0	86,043.9	79,837.0	73,436.9	77,997.9	5,528.8	7,409.0	-2.3%	(1,839.1)
72208	Ахмад настны хөгжил хамгаалал	186.7	720.7	178.3	178.3	178.3	-	702.7	0.0%	-
72209	Залуучууд болон оюутнууд	1,049.2	-	-	-	-	-	-	#DIV/0!	-
72212	Гэр бүлийн хөгжил, хамгаалал	15,254.5	37,668.0	19,349.9	18,987.9	11,603.1	-	31,724.7	-40.0%	(7,746.8)
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД		3,862,273.3	4,536,689.9	4,502,575.4	4,456,592.7	4,450,036.1	7,709.8	1,004,944.8	-1.2%	(52,539.2)

Дээрх хүснэгтээс авч үзвэл Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний зардлын санхүүжилт буурсан үзүүлэлттэй байна.

3. Орон тоо

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2025 онд Засгийн газрын тусгай сан 4, Нийгмийн даатгалын, Хөдөлмөр халамжийн, Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн гэсэн 4 салбарын нийт 119 төсөвт байгууллага, 4876 орон тоотой ажиллахаар төсвийн хязгаарт багтаан төлөвлөв.

Төсвийн хязгаарт батлагдсан орон тоонд багтаагүй дараах орон тоог нэмэгдүүлэх санал хүргүүлж байна..

- Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон барилга, байгууламжтай холбоотой 127 төрийн үйлчилгээний ажилтан шинээр нэмэгдэх;
- Засгийн газрын 2024 оны 143, 237 дугаар тогтоолоор аймаг, дүүргийн ГБХХГ, хэлтэст сум, хороонд томилогдон ажиллаж байгаа 758 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны цалин, нэмэгдэл, урамшууллын зардал 2025 оны батлагдсан төсөвт тусгагдсан боловч орон тоо тусгагдаагүй байсан;

  Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 2.2 дугаар зүйлд "Хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалт" сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан байна гэж заасантай холбогдуулан МУЗГ-ын 2024 оны 237 дугаар тогтоолоор сум, хороонд ажиллах 833 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог баталж 2025 оны 01 дүгээр сараас ажиллаж эхэлсэн бөгөөд төсвийн тодотголоор 9 хувийг бууруулан одоо 758 нийгмийн ажилтан ажиллаж байна.

---oOo---

1.1.ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГУУДЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1.1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН:

Нийгмийн халамжийн анхны бие даасан хуулийг 1995 онд баталж, 2000, 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, 1998, 2005, 2012 онд тус тус шинэчлэн найруулж байсан.

Монгол Улсад нийгмийн халамжийн чиглэлийн 6 хуулийн хүрээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, алдар цолтой ахмад настан, хүүхэд, эхчүүд болон нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэдэд 12 төрлийн халамжийн хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

Нийгмийн халамжийн сангийн 2026 оны төсвийн саналыг одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээс 2025 онд шинэчлэн батлагдсан Ахмад настны тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Засгийн газрын тогтоол бусад эрх бүхий байгууллагаас баталсан үнэ, тарифын өөрчлөлтүүд, хүн амын ердийн өсөлт, өмнөх 3 жилийн төсвийн гүйцэтгэл, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн төлөвлөв.

Нийгмийн халамжийн сангаас 2026 онд олгох хөнгөлөлт, тусламж, үйлчилгээнд 2,639.4 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон бөгөөд 2,518.9 тэрбум төгрөгийг төсвийн хязгаарт багтаан тооцож, 120.4 тэрбум төгрөгийг халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүний тоо, халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн өсөлттэй уялдуулан нэмэлтээр тооцлоо.

Нийгмийн халамжийн сангаас олгох нийт хөнгөлөлт, тусламж, үйлчилгээний зардлын 60.2 хувийг 1,603.5 сая төгийг хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардал эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангийн 2026 оны төсвийн саналд:

- Зорилтот бүлэгт чиглэсэн халамжийн тусламж, үйлчилгээний зардалд 868.3 тэрбум төгрөг 32,59 хувийг;
- Нийгмийн халамжийн сангаас эх хүүхдэд чиглэсэн гэр бүлийг дэмжих зардалд 1,726.1 тэрбум төгрөг 67.38 хувийг;
- Үйл ажиллагааны зардалд 0.8 тэрбум төгрөг 0.03 хувийг тус тус зарцуулахаар тооцов.



Нийгмийн халамжийн тэтгэвэр:

Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн сүүлийн 2 жилийн гүйцэтгэлийн дундаж үзүүлэлтийг авч үзвэл 2023 онд 62,631 иргэн, 2024 онд 61,003 иргэн тус тус хамрагдсан.

2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд "..... хөдөлмөрийн чадвараа алдахын өмнөх сүүлийн 5 жилд нийтдээ 36 ба түүнээс дээш сар төлсөн даатгуулагч ердийн өвчин,

ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй" гэж заасантай холбогдуулан, нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тогтоолгон авч байгаа иргэд явцын дунд нийгмийн даатгалын шимтгэл төлж, хуульд заасан шимтгэл төлсөн хугацааг хангаснаар нийгмийн даатгалаас тэтгэвэр тогтоолгох нь эрх зүйн хувьд боломжгүй болсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн даатгалын санд шимтгэл төлж, тэтгэвэр, тэтгэмж авах нөхцөл шалгуур өндөр болсон тул нийгмийн халамжид хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 2024 оноос эхлэн нэмэгдэх хандлагатай байна.

2026 онд Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдах хүний тоог сүүлийн 3 жилийн дунджаар 2,817 иргэн нэмэгдэхээр тооцон 63,820 иргэнд 311.1 тэрбум төгрөг, инфляцын түвшинтэй уялдуулан 8 хувиар нэмэгдүүлэх эх үүсвэрийг 30.6 тэрбум төгрөгөөр тус тус тооцов.

Асаргааны тэтгэмж:

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 122 дугаар тогтоолоор асаргааны тэтгэмжийн хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 302.500 төгрөгөөр шинэчлэн тогтоосон бол мөн оны 247 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээ, ялгаатай нөхцөл байдлыг харгалзан байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмжийн хэмжээг сард 445.000 төгрөгөөр шинэчлэн тогтоож, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн даган мөрдөж байна.

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/807, А/216 дугаар хамтарсан тушаалаар “байнгын асаргаа шаардлагатай иргэний өвчин гэмтлийн жагсаалт”-ыг шинэчлэн баталсан. “Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт”-д нийт 58 онош шинээр нэмэгдэж, хугацаагүйгээр тогтоох хүүхдийн нийт 29 өвчин, гэмтлийн заалтыг нэмж баталсан байна. Мөн “байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний өвчин, гэмтлийн жагсаалт”-д 20 өвчин, гэмтлийн оношийг байнгын асаргаа тогтоохдоо “хугацаагүй” байхаар өөрчилсөн. Эдгээрээс шалтгаалан асаргааны тэтгэмжид хамрагдах хүний тоо харьцангуй өсөлттэй байна.

2024 онд байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа 15,064 иргэн байгаа бол үүнээс хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа 6,000 гаруй иргэн байна. /Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссоос байнгын асаргаа шаардлагатай хүүхдийг хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дахин магадлах арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулж байна.

Асаргааны тэтгэмжид хамрагдсан иргэдийн сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дундаж үзүүлэлтийг авч үзвэл 2022 онд 65,865 иргэн, 2023 онд 69,959 иргэн, 2024 онд 77,844 иргэн тус тус хамрагдсан ба сүүлийн 3 жилийн дунджаар жилд 4,218 иргэн нэмэгдсэн.

2026 онд өмнөх оны хүлээгдэж буй гүйцэтгэл, сүүлийн 3 жилийн дундаж өсөлт, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс ирүүлсэн саналд үндэслэн 4,962 иргэн нэмэгдэхээр тооцон нийт 82,806 иргэнд 311.2 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.

Эхийн алдар одонтой эхэд олгох мөнгөн тусламж:

Хууль, эрх зүйн өөрчлөлт:

- Засгийн газрын 2024 оны 255 дугаар тогтоолоор мөнгөн тусламжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж, "Эхийн алдар" нэгдүгээр одонтой эхэд олгох мөнгөн тусламжийн хэмжээг 400,000 төгрөгөөр, хоёрдугаар одонтой эхэд олгох мөнгөн тусламжийн хэмжээг 200,000 төгрөгөөр тус тус тогтоосон.
- Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар "Олон хүүхэд төрүүлж өсгөн эхийг урамшуулах тухай хууль"-д оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн 3.2-д "Энэ хуулийн 3.1.1-д заасан "дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн" гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр үед гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд, байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхэд хамаарах ба харин эхийн төрүүлж бусдад үрчлүүлсэн хүүхэд хамаарахгүй" гэж шинэчлэн баталсан. Үүний дагуу "Эхийн алдар одонтой эхэд мөнгөн тусламж олгох журам"-ын 2.3.2-д "эх хүсэлт гаргасан бол нэг ба түүнээс дээш настай нас барсан хүүхдийг" Эхийн алдар одонгоор шагнагдах хүүхдийн тоонд хамруулахаар заасан.

Төсвийн гүйцэтгэл: Эхийн алдар одонтой ээжүүдэд 2022 онд 246,686 эхэд 31.0 тэрбум төгрөг, 2023 онд 252,678 эхэд 31.5 тэрбум төгрөг, 2024 онд 259,746 эхэд 32.1 тэрбум төгрөгийн мөнгөн тусламжийг нийгмийн халамжийн сангаас олгосон бөгөөд мөнгөн тусламжийн хэмжээ нэмэгдсэнээр 2025 онд 68.3 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвлөсөн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2023 онд 10,836 эх, 2024 онд 11,317 эх, 2025 онд 14.486 эх, Эхийн алдар одонгоор шагнагдсан байна.

Хүн амын өсөлтийн улмаас Эхийн алдар одонгийн мөнгөн тусламжид хамрагдах эхчүүдийн тоо жилээс жилд нэмэгдэх төлөвтэй байна. Мөн Олон хүүхэд төрүүлж өсгөн эхийг урамшуулах тухай хуульд нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр үед гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд, байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхэд хамруулахаар шинэчлэн баталсан.

Энэ хуулийн шинэчлэлийн хүрээнд 2025-2026 онд 7363 эхэд "Эхийн алдар" одон нөхөн олгох, мөнгөн тусламжид хамрагдсан эхийн хэвийн өсөлтийг сүүлийн 3 жилийн дунджаар 6,815 эх, нийт 14,507 эх шинээр нэмэгдэхээр тооцож 2026 онд 274,253 эхэд 67.6 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвлөв.

Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж:

Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэл насны хүүхдэд нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээгээр, байнгын асаргаа шаардлагатай 16-аас дээш насны иргэнд улиралд нэг удаа 60.0 мянган төгрөгийн тэтгэмжийг олгодог бөгөөд амьжиргааг дэмжих энэ 2 төрлийн тэтгэмжийг улсын төсвөөс санхүүжүүлж байна.

Хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчний тохиолдол нэмэгдэх, бага насны хүүхдийн дунд ахуйн осол гэмтэл болон хорт хавдрын өвчлөл нэмэгдэж байгаагаас төрөлхийн болон олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болсон хүүхдийн тоо өсөж байнгын асаргааны тэтгэмж тогтоолгох байдал нэмэгдсээр байна.

Мөн Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/807, А/216 дугаар хамтарсан тушаалаар байнгын асаргаа

шаардлагатай иргэний өвчин гэмтлийн жагсаалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдах хүний тоо өсөж байна.

Тус тэтгэмжид 2022 онд 58,583 иргэн, 2023 онд 63,112 иргэн, 2024 онд 70,861 иргэн тус тус хамрагдсан бөгөөд жилийн дундаж өсөлт 4,373 ба сүүлийн 2 жилд 4529-7749 хүнээр нэмэгдсэн. 2026 онд 5506 хүнээр нэмэгдүүлж 92,692.6 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох тэтгэмжийн хэмжээг 8.0 хувь нэмэгдүүлэх эх үүсвэр 16,416 хүүхдэд 6,264.3 сая төгрөг шаардлагатай байна.

Хүүхдийн мөнгөн тэтгэмж:

Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 247 дугаар тогтоолоор "Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 236 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам"-д өөрчлөлт орж, журмын 1.1 дэх заалтын "Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхдэд" гэснийг "Монгол Улсын иргэн болон Монгол Улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын гэрээтэй Монгол Улсад хууль ёсоор оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүний 0-18 насны хүртэлх насны хүүхдэд" гэж өөрчилсөн.

Гадаад иргэн, харьяатын газрын 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн ирүүлсэн тоон мэдээнд дурдсан Монгол Улсад хууль ёсоор оршин суудаг 29,956 гадаадын иргэний 0-17 насны 3,279 хүүхэд дээрх тогтоолын хүрээнд Хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдах юм. Үүнд: ОХУ, БНСУ, Унгар, Польш, Турк, Чех.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 2022 онд 1,237,490 хүүхдэд 1,485.0 тэрбум төгрөг, 2023 онд 1,305,322 хүүхдэд 1,520.1 тэрбум төгрөг, 2024 онд 1,340,971 хүүхдэд 1,540.0 тэрбум төгрөг тус тус зарцуулсан бөгөөд 2025 онд 1,340,971 хүүхдэд 1,568.5 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд сүүлийн 3 жилийн дунджаар жилд 40,271 хүүхэд нэмэгдэж хамрагдсан байна.

Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн нэгдсэн санд оруулсан мэдээллээр 2024 онд 60,000 орчим хүүхэд шинээр төрсөн, 31,500 орчим хүүхэд 18 насанд хүрсэн, 1,500 орчим хүүхэд нас барсан, Гадаадын иргэн, харьяатын газраас авсан мэдээллээр гадаадын иргэн, гэр бүлд 300 хүүхэд үрчлэгдэн Монгол Улсын харьяатаас гарсан байна. Мөн гадаадын иргэн, харьяалалгүй хүний 0-18 насны 1,300 хүүхэд байна. 2026 онд дээрх тоон мэдээлэлд үндэслэн жилд дунджаар 18,048 хүүхэд шинээр хамруулж дунджаар 1,359,011 хүүхдэд 1,603.6 тэрбум төгрөг олгохоор тооцов.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ:

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар батлагдсан "Хүнсний эрхийн бичиг олгох журам"-ын дагуу үзүүлж байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 29.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь Өрхийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах, тухай бүр шинэчлэх үүрэгтэй. Энэ ажлын хүрээнд 2023 онд 27,000 өрх, 2024 онд 11,000 өрхөөс судалгааг авч өрхийн мэдээллийн нэгдсэн санг баяжуулсан. 2025 онд 178,000 өрхийн жагсаалт үүсгэн судалгаа авах ажил үргэлжлэн хийгдэж байгаа бөгөөд тус мэдээллийн санд үндэслэн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг үзүүлнэ.

Тус мэдээллийн сангаас үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний журам шинэчлэн батлагдах юм. Шинэчлэн батлагдах журмаар босго шугамыг одоогийн хэрэгжиж буй босго шугамыг 292,5 оноо гэж тооцвол 51,501 өрхийн

278,308 иргэн байгаагаас аргачлалын алдаагаар хасагдах магадлалтай 35.0 хувийг хасч тооцвол 33,436 өрхийн 180,900 иргэн хамрагдах боломжтой байна.

Мөн босго шугамыг 200 оноогоор татвал 33,825 өрхийн 187,308 иргэн байгаагаас аргачлалын алдаагаар хасагдах магадлалтай 35.0 хувийг хасаж тооцвол 21,986 өрхийн 128,967 иргэн хамрагдах юм. **Иймд 2026 онд 39,261 иргэн нэмж хамруулан, 19.0 тэрбум төгрөг олгохоор тооцов.**

Насны хишиг:

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Насны хишгийн журам батлах тухай" 244 дүгээр тогтоолоор журмыг шинэчлэн баталсан. Журмын өөрчлөлтийн 2.14-т "Энэ журмын 1.2-т заасан болзол ханган, насны хишиг авах хүсэлт гаргасан ахмад настан 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө төрсөн бол насны хишгийг 06 дугаар сард, 06 дугаар сарын 01-ний өдрөөс хойш төрсөн бол дараа оны 01 дүгээр сард нөхөн олгох"-оор заасан тул тухайн оны 06 сарын 01-ний өдрөөс өмнө төрсөн ахмад настанд жилд 2 удаа насны хишиг олгох ба 06 сарын 01-ний өдрөөс хойш төрсөн ахмад настанд дараа онд нөхөн олгохоор өөрчлөлт орсон.

2021 онд 157,697 ахмад настан хамрагдаж, 24,028.6 сая төгрөгийн, 2022 онд 168,201 ахмад настан хамрагдаж, 25,063.1 сая төгрөгийн, 2023 онд 176,929 ахмад настан хамрагдаж, 26,662.3 сая төгрөгийн, 2024 онд 191,275 ахмад настан хамрагдаж, 28,375.9 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. Сүүлийн 3 жилийн дунджаар жилд 11,193 ахмад настан шинээр нэмэгдэж, 1,449.0 сая төгрөгийн насны хишгийн санхүүжилт олгосон байна.

2024 оны гүйцэтгэлийг 2025 оны 06 дугаар сарын гүйцэтгэлтэй харьцуулахад 14,988 ахмад настан шинээр болон насны бүлэг дэвшиж нийт 30,306.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнээс насны бүлэг дэвшсэн дүнгээр авч үзвэл:

1. 65-69 насны 8,494 ахмад настан шинээр хамрагдаж 849.3 сая төгрөг.
2. 70-79 насны 5,378 ахмад настан насны бүлэг дэвшиж 846.9 сая төгрөг.
3. 80-89 насны 859 ахмад настан насны бүлэг дэвшиж 267.0 сая төгрөг.
4. 90 ба түүнээс дээш насны 257 ахмад настан насны бүлэг дэвшиж 129.3 сая төгрөг

тус тус нэмэгдэж **2092,5 сая төгрөгийн зардал нэмэгдсэн.** Журамд заасны дагуу 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хойш төрсөн бол дараа оны 01 дүгээр сард өмнөх оны /Ардын хувьсгалын ойн баяр наадмыг тохиолдуулан олгох насны хишгийг/ нөхөн олгохоор заасны дагуу 4,090 ахмад настанд 2026 оны 01 дүгээр сард өмнөх оны насны хишгийн нөхөн олголтод 826.0 сая төгрөгийг нэмж олгохоор байна.

2026 онд нийт 19,077 ахмад настан нэмэгдэж 210,352 ахмад настанд 33.6 тэрбум төгрөг олгохоор тооцов.

Цаашид нийт хүн амд 2025 оноос эхлэн нөхөн үржихүйн идэвхтэй насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь буурч, ахмад насныхан бусад насны бүлгийн хүн амаас илүү хурдацтай өсөх хандлагатай байна.

Цалинтай ээж хөтөлбөр:

<u>0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж:</u> Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээр 2023 онд 66,234 эх, 2024 онд 57,800 эх тус тус амаржсан бөгөөд сүүлийн 2 жилийн дунджаар тооцвол төрөлтийн хувь 14.5 хувиар буурсан байна. Тус хөтөлбөрт 2023 онд 184,754 иргэнд 77,892.2 сая төгрөгийн, 2024 онд 172,109 иргэнд 73,212.4 сая төгрөгийн мөнгөн тэтгэмжийг халамжийн сангаас тус тус олгосон.

2026 оны төсвийн төслийн саналыг аймаг, дүүргийн ХХҮГазар, хэлтсээс ирүүлсэн саналыг үндэслэн 2025 оны батлагдсан төсвийг нэмэгдүүлэхгүй байхаар тооцон 78.8 тэрбум төгрөг олгохоор тооцов.

Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж: Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийн мөнгөн дүнг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны тогтоосон тухайн үед мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон улирал бүр олгож байна.

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 онд 550.000, 2024 онд 660.000, 2025 онд 792.000 төгрөгөөр тус тус тогтоосон. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний сүүлийн 3 жилийн дундаж өсөлт нь 20 хувь буюу 158.400 төгрөг байна.

Төсвийн гүйцэтгэлээр тус тэтгэмжид 2022 онд 8343, 2023 онд 8,462, 2024 онд 8,812 эх эцэг хамрагдсан байна. Сүүлийн 3 жилийн дунджаар жилд 262 эцэг, эх энэ тэтгэмжид шинээр хамрагдаж байна.

2026 онд аймаг, дүүргийн ХХҮГ, хэлтсийн саналд үндэслэн 154 эцэг, эх нэмж хамрагдахаар 487.9 сая төгрөгийн төсөв нэмэгдүүлж тус тэтгэмжийн зардлыг 28.4 тэрбум төгрөг олгохоор тооцов.

Ихэр хүүхдийн тэтгэмж: Тэтгэмжид 2023 онд 737 ихэр хүүхдэд 1,509.0 сая төгрөгийн, 2024 онд 762 ихэр хүүхдэд 1,406.0 сая төгрөгийг тус тус олгосон. Тус тэтгэмжид сүүлийн 2 жилд дунджаар 740 иргэн хамрагдсан байна. 2026 оны төсвийг аймаг, дүүргийн ХХҮГ, хэлтсээс ирүүлсэн саналд үндэслэн 133 иргэн, 401.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 815 ихэр хүүхдэд 1.8 тэрбум төгрөг олгохоор тооцов.

Жирэмсэн эхийн тэтгэмж:

Тус тэтгэмжид 2023 онд 73,811 иргэнд 10,139.6 сая төгрөг, 2024 онд 67,205 иргэнд 8,974.8 сая төгрөг тус тус олгосон. Сүүлийн 2 жилд дунджаар 70,508 иргэн хамрагдсан бөгөөд 2023 онд 3,764, 2024 онд 6,606 иргэнээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2025 онд төсөвт 66,205 иргэн хамруулж 9.8 тэрбум төгрөг олгохоор батлагдсан бөгөөд 2026 онд 2025 оны батлагдсан төсвийг бууруулахгүй байхаар тооцов.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

Хууль, эрх зүйн өөрчлөлт

- Нийгмийн халамжийн тухай хуулийн 19[1].2-т "Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлж байгаа гэр бүл, хуулийн этгээдэд олгох **хувьсах болон үйлчилгээний зардлыг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ.[2]";**
- Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.11-т "Энэ хуулийн 19.1.1[3]-д заасан үйлчилгээг шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуйн нэгж, байгууллагад **төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлж болно."**
- Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.13-т"Энэ хуулийн 19.5.1-д заасан нэг хүнд ногдох зардлын нормативыг байгын асаргаа шаардлагатай иргэнд **3 дахин нэмэгдүүлэн тооцно." гэж заасан.**
- Мөн Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 245 дугаар тогтоолоор "Ахмад настны асрамжийн үйлчилгээ шинээр үзүүлэх, барилга байгууламж барих

- [2] 19[1].1. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд Хүүхэд хамгаллын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу гэр бүлээс нь тусгаарлагдсан хүүхдийг хамруулна.
- [3] 19.1.1. ахмад настны асрамжийн үйлчилгээ;

аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэх журам"-ыг шинээр баталсан.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.Энэ хуулийн 26.2-т заасан "иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үзүүлэх нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөв, халамжийн сангаас гэрээний үндсэн дээр хэсэгчлэн буюу бүрэн санхүүжүүлж болно" гэж заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай 119 иргэнд төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа 2 асрамжийн газарт нийгмийн халамжийн сангаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн "Зардлын норматив шинэчлэн батлах тухай" А/130 дугаар тушаалын хавсралтаар баталсан эм, хоол, хувцасны норматив зардалд 2024 онд 0.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

- Нийгмийн халамжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгагдсан 19.13 дахь заалтын хүрээнд 2025 онд тус 2 асрамжийн байгууллагад асруулж байгаа байнгын асаргаа шаардлагатай иргэдэд олгох зардлын нормативыг 3 дахин нэмэгдүүлж 1.7 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд 2026 онд хувийн асрамжийн байгууллага нэмэгдэхгүй тул норматив зардлыг нэмэгдүүлж тооцоогүй болно.
- Ахмад настны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 245 дугаар тогтоолоор баталсан "Ахмад настны асрамжийн үйлчилгээ шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэх журам"-ын дагуу 50 ба түүнээс дээш тооны асруулагчтай, барилгын ажлын гүйцэтгэл нь 50-аас дээш хувьтай, эсхүл барилга, байгууламж шинээр худалдан авсан байгууллагад 500,0 хүртэл сая төгрөгийн нэг удаагийн дэмжлэг үзүүлэхээр болсон. Энэ журмын дагуу шаардлага хангасан нэг байгууллагад 2026 онд 500.0 сая төгрөг олгохоор нэмж төсөвлөв. Уг заалттай холбогдуулан дэмжлэг хүссэн хувийн хэвшлийн асрамжийн газрын тоо нэмэгдэж байна.
- Хүүхэд хамгааллын тухай хууль 2024 онд шинэчлэн батлагдсантай холбогдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийн 19[1].2-т "Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлж байгаа гэр бүл, хуулийн этгээдэд олгох хувьсах болон үйлчилгээний зардлыг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ."[4] гэсэн заалтын хүрээнд нийт 16 хүүхдийн асрамж, халамжийн төвд амьдарч байгаа 550 хүүхдэд 4.8 тэрбум төгрөгийн хувцас, эм, хоолны зардал олгохоор нэмж төсөвлөв.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний зардалд 2026 онд насанд хүрэгч 119, хүүхдийн асрамж, халамжийн төвийн 550 хүүхэд, нийт 669 хүн хамруулж 6.9 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвлөв.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох хөнгөлөлт, тусламж:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан хөнгөлөлт, тусламжид хөгжлийн бэрхшээлтэй хүн жилд 1 удаа, 3 жилд 1 удаа хамрагдах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд протезын хэрэгслийг бие эрхтний өсөлтөөс шалтгаалан тухай бүр хөнгөлөлттэй үнээр авах хуулийн зохицуулалттай. Хуульд заасан шалгуурыг хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүн хэдэн ч үйлчилгээнд хамрагдах эрхтэй байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 248 дугаар тогтоолоор Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийн[5] 66 дах хэсэгт байнгын асаргаа шаардлагатай хүнд

[4] 19[1].1. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу гэр бүлээс нь тусгаарлагдсан хүүхдийг хамруулна.

[5] Засгийн газрын 2021 оны 363 дугаар тогтоолоор баталсан

хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 2-оос дээш насны 3000 хүүхдэд жилд 2 удаа 300,0 мянган төгрөгийн памперс /живх/-ний үнэ олгохоор 1,800.0 сая төгрөг;

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг сургуульд ирж, очих унааны зардлын хөнгөлөлтөд 2021 онд 3531, 2022 онд 4758, 2023 онд 5995, 2024 онд 6702 иргэн тус тус хамрагдсан бөгөөд сүүлийн 3 жилийн дунджаар жилд 1057 иргэн нэмэгдсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох хөнгөлөлт, тусламжид 2025 онд 49,505 иргэн хамрагдаж 13,348.0 сая төгрөгөөр олгох төсөвлөгдсөн 2026 онд аймаг, дүүргийн ХХҮГ, хэлтсийн ирүүлсэн саналд үндэслэн 9747 иргэн нэмэгдүүлж 59,252 иргэн хамруулж 15.8 тэрбум төгрөг олгохоор тооцов.

Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлттусламж:

Алдар цолтон ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөд 2024 онд 3,630 ахмад настан хамрагдаж, 934.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон. 2025 оны батлагдсан төсөв, хүний тоог 434 ахмад настан, 461.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцож, 2026 онд нийтдээ 4,199 ахмад настан, 1.2 тэрбум төгрөгийн зардал тооцов.

Буцалтгүй тусламжийн зардал:

Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтын төлөө мэдлэг боловсрол, бие сэтгэл, хүч чадлаа дайчлан гавьяа байгуулж Монгол Улсын баатар, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Төрийн эрхэм дээд цол хүртсэн ахмад настанд насны эрэмбээр тооцож 80-аас дээш өндөр настанд 50.0 сая төгрөг, эмэгтэй 55-79, эрэгтэй 60-79 хүртэлх насны ахмад настанд 30.0 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 135 ахмад настанд нийт 5.4 тэрбум төгрөг тооцон тусгав.

Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт:

Монгол Улсын хувьд 60 ба түүнээс дээш насны ахмад настны тоо 2000 онд нийт хүн амын 5.4 хувь, 2010 онд 5.8 хувь, 2021 онд 9.7 хувь, 2024 онд 10,9[6] хувь байсан бол 2030 онд 11.9 хувь, 2050 он гэхэд 5 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс дээш настай болох магадлалтайг Үндэсний статистикийн хорооноос тооцоолжээ. 2024 оны байдлаар Монгол Улсын нийт ахмад настны тоо 406.3 мянга болж, 2021 оноос хойш жил бүр дунджаар 5.0 орчим хувиар нэмэгдэж байна.

Дээрх хүн ам зүйн өөрчлөлт, ахмад настнуудын тоо өсөж байгаатай уялдуулан ахмад настны нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах шаардлага тулгарч, Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Ахмад настны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт:

- 7.1.7. ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ[7], 7.1.10. ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээ, 7.1.11. ахмад настны зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл

[6] 2024.10.01-ний өдрийн байдлаар 385,246 ахмад настан байна

- [7] 4.1.9."ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ" гэж ахмад настны асруулах эрэлт хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн ахмад настныг төрөлжсөн асрамжийн, гэрээр, асралт гэр бүлээр, өдрөөр, түр, урт хугацаагаар, байнга асрах үйлчилгээг төрийн байгууллага иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар дамжуулан, эсхүл хамтран төлбөртэй, төлбөрийн хөнгөлөлттэй, төлбөргүй нөхцөлөөр үзүүлэх үйл ажиллагааг;

мэндийг дэмжих үйлчилгээ, 7.1.12. ахмад настанд үзүүлэх сэргээн засах үйлчилгээ[89] тус тус шинээр хэрэгжүүлэхээр нэмэгдсэн;

- 8.1.1.хөл, гар, шүдний протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл, тэргэнцэр, нэн шаардлагатай тусгай хэрэгсэл худалдан авсан зардлын үнийн хөнгөлөлтийг 5 жилд нэг удаа олгож байсныг 3 жилд нэг удаа нийгмийн халамжийн сангаас олгохоор заасан.
- 13.6. Энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7, 7.1.8, 7.1.9, 7.1.10, 7.1.11-д заасан үйлчилгээнд зарцуулах хөрөнгө нийгмийн халамжийн сангаас ахмад настанд зарцуулах нийт хөрөнгийн 10 хувиас багагүй байна.
- 10.1.2-т эмчилгээ сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настан эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд гэснийг хасаж, сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн жишиг үнийн 50 хувийг, хүндэт донор ахмад настанд 100 хувийг жилд нэг удаа олгохоор заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 159 дүгээр тогтоолоор ахмад настанд хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүлэх амралт, сувиллын газарт ахмад настан амарч, сувилуулах хугацааг 7 хүртэлх хоногоор, эрхийн бичгийн нэг ор хоногт нийгмийн халамжийн сангаас олгох хөнгөлөлтийн хэмжээг амралтын газарт 35,000 (гучин таван мянган) төгрөгөөр, сувиллын газарт 40,000 (дөчин мянган) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон. /15.0-20.0 мянган төгрөг байсан/

Ахмад настны тухай хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой дараах журам, зардлын жишиг үнийг шинээр баталсан.

- ГБХНХ-ын болон Сангийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 24-ны өдийн А51, А37 дугаар хамтарсан тушаалаар "Ахмад настанд үзүүлэх жишиг үнэ, иргэний хариуцах төлбөрийн хэмжээ"-г баталсан.
  - Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээний жишиг үнэ
  - Гэрээр асрах /явуулын/ үйлчилгээний жишиг үнэ
  - Өдрөөр асрах /өдрийн/ үйлчилгээний жишиг үнэ
- ГБХНХ-ын болон Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А75, А514 дугаар хамтарсан тушаалаар "Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам"
- ГБХНХ-ын болон Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А76, А515 дугаар хамтарсан тушаалаар "Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам" зэрэг болно.

Ахмад настны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ахмад настны үйлчилгээний төрөл, хэлбэрийг өргөжүүлж ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээ, ахмад настны зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ, байнгын асаргаа шаардлагаттай ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ /өдрөөр асрах, гэрээр очиж асрах, түр, урт хугацаагаар, байнга асрах зэрэг үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэхээр тусгасан.

Ахмад настны хам шинжийг цогцоор үнэлэх, үнэлгээний үр дүн, эрэлт хэрэгцээнд үндэслэн Идэвхтэй насжилтыг дэмжих төвөөр үзүүлэх үйлчилгээ болон асаргааны хувилбарт үйлчилгээг үзүүлэх журам, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах

---

[8] 4.1.10."ахмад настанд үзүүлэх сэргээн засах үйлчилгээ" гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.21-д заасан сэргээн засах цогц үйл ажиллагааг ахмад настанд үзүүлэхийг;

журмуудыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар, үйлчилгээний жишиг үнэ, иргэний хариуцах төлбөрийн хэмжээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар тус тус батлан хэрэгжүүлэх бэлтгэл ажил бүрэн хангагдсан боловч одоогийн байдлаар сонгон шалгаруулалт зарлаж, үйлчилгээг хэрэгжүүлэхэд санхүүжилт батлагдаагүй.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн "Үйлчилгээний жишиг үнэ, иргэний хариуцах төлбөрийн хэмжээ батлах тухай" А/51,37 дугаар хамтарсан тушаалын дагуу Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ үзүүлэх нэг байгууллагад олгох үйлчилгээний жишиг үнэ 103.2 сая төгрөг, асаргааны хувилбарт үйлчилгээ (өдрөөр асрах, гэрээр асрах, урт түр, байнга асрах)-ний жишиг үнэ халамжийн сан болон иргэний оролцоотойгоор нэг хүнд нэг өдрийн 50.000-70.000 төгрөгөөр батлагдсан. Улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүрэг, нийт 30 нэгжид ахмад настны Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээг үзүүлэх байгууллага 2, асаргааны хувилбарт үйлчилгээний төрлүүдээс хамгийн багадаа 1-2 төрлийн үйлчилгээг үзүүлэхээр тооцоход ахмад настны үйлчилгээнд нэг нэгжид 260.0 сая орчим төгрөг зарцуулахаар байна.

Ахмад настны тухай хуулийн 13.6-д ахмадын үйлчилгээнд зарцуулах хөрөнгө нийгмийн халамжийн сангаас ахмад настанд зарцуулах нийт хөрөнгийн 10 хувиас багагүй байхаар хуульчилсан бөгөөд 2023 оны гүйцэтгэлээр ахмад настанд зарцуулсан нийт хөрөнгийн 10 хувь буюу 22.0 тэрбум төгрөгөөс багагүй байхаар тооцоо гарсан боловч үйлчилгээний санхүүжилт дээрх хэмжээгээр батлагдаагүй нь нэг талаас хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх, нөгөө талаас ахмад настан үйлчилгээ авах эрхээ эдэлж чадахгүй байх нөхцөл байдал үүсэхээр байна.

Ахмад настны хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах асуудлыг УИХ болон холбогдох байгууллага, иргэдээс шаардаж байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийг хянах зөвлөл УИХ-ын даргын дэргэд байгуулагдсан.

Ахмад настны тухай хуульд заасан хөнгөлөлт, үйлчилгээнд 2024 оны төсвийн гүйцэтгэлээр 322,361 ахмад настан хамрагдаж 38.6 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд 2025 онд 33.6 тэрбум төгрөг болж буурч батлагдсан нь энэ төрлийн үйлчилгээний зарим хөнгөлөлтийн хэмжээ нэмэгдсэн болон хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой шинэ төрлийн үйлчилгээг хэрэгжүүлэх боломжгүй болоод байна. Тухайлбал:

- Магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан, сувиллын үйлчилгээнд 2021 онд 14,992 ахмад настан хамрагдаж, 2,518.2 сая төгрөгийг, 2022 онд 40,402 ахмад настан хамрагдаж, 6,153.9 сая төгрөгийг, 2023 онд 37,175 ахмад настан хамрагдаж, 6,151.4 сая төгрөгийг, 2024 онд 50,453 ахмад настан хамрагдаж, 8,445.4 сая төгрөгийг тус тус олгосон байна. Сүүлийн 3 жилийн дунджаар жилд 11,820 ахмад настан тус үйлчилгээнд шинээр хамрагдаж, 1,975.7 сая төгрөгийн санхүүжилтийг нэмж олгосон байна. *Хуулийн шинэчлэлтээр "рашаан" гэсэн заалт хасагдсан тул үйлчилгээ үзүүлэх байгууллагын тоо 2 дахин нэмэгдсэн.*
- Эрхийн бичгийн хөнгөлөлттэй үнээр үзүүлэх амралт, сувиллын үйлчилгээнд 2021 онд 25,515 ахмад настан хамрагдаж, 4,408.6 сая төгрөг, 2022 онд 49,913 ахмад настан хамрагдаж, 8,195.6 сая төгрөг, 2023 онд 52,153 ахмад настан хамрагдаж, 8,289.3 сая төгрөг, 2024 онд 61,127 ахмад настан хамрагдаж, 14,879.5 сая төгрөг тус тус олгосон байна. Сүүлийн 3 жилийн дунджаар жилд 11,871 ахмад настан тус үйлчилгээнд шинээр хамрагдаж, 2,490.2 сая төгрөгийн санхүүжилтээр нэмэгдэж байна.

Ахмад настны тухай хууль, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн хүрээнд ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлтөд 2021 онд

214,123 ахмад, 2022 онд 282,738 ахмад, 2023 онд 314,751 ахмад, 2024 онд 322,361 иргэн тус тус хамрагдсан бөгөөд сүүлийн 3 жилийн дунджаар авч үзвэл жилд 36,079 ахмад настан нэмэгддэг бөгөөд жилээс жилд хүн амын бүлэгт ахмад настны эзлэх хувь нэмэгдэж байна.

Ахмад настны тухай хуулийн хүрээнд ахмад настанд үзүүлэх үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор хуулийн 13.6. "Энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7, 7.1.8, 7.1.9, 7.1.10, 7.1.11-д заасан үйлчилгээнд зарцуулах хөрөнгө нийгмийн халамжийн сангаас ахмад настанд зарцуулах нийт хөрөнгийн 10 хувиас багагүй байна" гэсэн заалтын хүрээнд ахмад настанд идэвхтэй насжилтыг дэмжих болон асаргааны хувилбарт үйлчилгээ зэрэг хуульд заасан шинэ төрлийн үйлчилгээг хэрэгжүүлэхээр 15.5 тэрбум төгрөг нэмж тооцов.

- Ахмад настанд 2024 онд үзүүлэх нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмж, улирлын амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, насны хишиг, ахмадын үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг хөнгөлөлт, алдар цолтон ахмад настны хөнгөлөлт, эхийн алдар одонтой ахмад настан ээжүүд, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, мөн онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настанд олгосон санхүүжилтийн гүйцэтгэлээр тооцоход нийт 220.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- Үүний 10 хувь гэж тооцоход 22.1 тэрбум төгрөг болж байгаа ба 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн тооцоонд уг зардлыг 30 хувиар бууруулан тооцож 15.5 тэрбум төгрөг нэмж төсөвлөв.

Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн зардалд 2025 оны батлагдсан төсвөөс 11.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 281,962 ахмад настан хамруулж 44.2 тэрбум төгрөг төсөвлөв.

Дотоод албан томилолтын зардал:

Аймаг, нийслэлийн Хөдөлмөр халамжийн .үйлчилгээний байгууллагууд нийгмийн халамжийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд тавих хяналт шалгалт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулахад шаардагдах албан томилолтын зардлыг 2018 он хүртэл орон нутгийн төсвөөс батлан хэрэгжүүлдэг байсан. Халамжийн сангийн дийлэнх хөнгөлөлт, тусламж, үйлчилгээний зардлыг 2019 оноос улсын төсвөөс төвлөрсөн байдлаар хянаж, санхүүжүүлэх болсонтой холбоотой орон нутгийн хяналтын зардлын төсөв батлагдахгүй орхигдох болсон.

Хяналт шалгалт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх албан томилолтоор ажиллах төсөв дутагдалтай байгаа нь халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд шат шатны байгууллага байнгын хяналт тавьж ажиллахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсэхээс гадна халамжийн хөнгөлөлт, тусламж, үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэх төр засгийн бодлого алдагдах, Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байгаа үйлчилгээ чанаргүй хэрэгжих, зарцуулалтад тавих хяналт алдагдах эрсдэлтэй байна.

Иймд Нийгмийн халамжийн тухай хуулийн 8.2-д "Нийгмийн үйлчилгээний сангийн хөрөнгийг дараах үйлчилгээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна", 8.2.8-д "Нийгмийн халамжийн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх судалгаа, шинжилгээ, үнэлгээний зардал" гэж заасны дагуу 2026 онд дотоод албан томилолтын зардалд 75.1 сая төгрөг тооцож төсөвлөв.

Мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх зардал:

Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГазар нь 2020 оноос эхлэн Халамжийн нэгдсэн систем /ehalamj.mn/-ийн хөгжүүлэлт болон найдвартай ажиллагааг хангаж ирсэн

Тус байгууллага нь "ehalamj.mn" Халамжийн нэгдсэн системээс дараах үйл ажиллагаанд иргэн рүү системээс автоматаар мэйл илгээх үйлчилгээ буюу Sendgrid-ийн үйлчилгээг ашиглан 2020 оноос цахим шуудан илгээж байна. Үүнд: иргэний ирүүлсэн хүсэлтийг баталгаажуулах, ирүүлсэн хүсэлтийг татгалзах, иргэний үйлчилгээг баталгаажуулах гэсэн үйлчилгээг үзүүлдэг байна.

Дээрх мэйлийг илгээснээр хэрэглэгч өөрийн илгээсэн хүсэлтэд системээр нэвтрэх бус цахим шуудан хүлээн авч шалгах, хянах, мэдэгдэл хүлээн авах боломжийг олгож байна.

2024 онд буюу нэг жилд 228,357 ширхэг мэйлийг системээс иргэд илгээсэн байна. Иймд 2026 онд цахим мэйлээр үйлчлэх мэдээллийн үйлчилгээний төлбөрт сард 499$ тооцоход /499$*3.590₮*12сар=21,496,920 төгрөг/ жилд тухайн мессэж үйлчилгээний төлбөрт 21.5 сая төгрөгийг төлөхөөр тооцов.

Нийгмийн халамжийн сангийн "finance.hudulmur-halamj.gov.mn" санхүүгийн програмын ашиглалтын лицензийн хугацаа 2025 оны 12-р сарын 31-нд дуусах ба уг санхүүгийн системийг шинэчлэхэд 70.0 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 8 дүгээр зүйлийн 8.2.7-т "".. мэдээллийн технологийн тогтолцоо бүрдүүлэх, шинэчлэхтэй холбогдсон зардал" гэж заасны дагуу 2026 оны төсвийн төслийн саналд "ehalamj.mn" Халамжийн нэгдсэн систем болон "finance.hudulmur-halamj.gov.mn" санхүүгийн програмын шинэчлэлд зориулж нийтдээ 91.5 сая төгрөгийг шинээр нэмж тооцож, уг саналыг хүргүүлж байна.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажил:

"Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлал"-ын дагуу 2023 оноос хойш 220,000 орчим өрхийг судалгаанд хамруулсан ба 2025 оны 04 дүгээр сарын байдлаар өрхийн мэдээллийн нэгдсэн санд өрхийн амьжиргааны түвшин нь үнэлэгдсэн 104,505 өрхийн мэдээлэл бүртгэлтэй байна.

Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/16, А/04 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлал"-ын дагуу судалгаа хийж, мэдээллийн санг баяжуулах чиглэлийг баримтлан 2025 оны 1 дүгээр удиралд нийт 181,355 өрхийг судалгаанд хамруулахаар төлөвлөсөн ба 39,1% буюу 70,989 өрхийг бүрэн үр дүнтэй судалгаанд хамруулсан.

Цаашид бүрэн үр дүнтэй судалгаанд хамруулаагүй өрхөөс судалгаа авах, өргөдөл, хүсэлтэд үндэслэн судалгаанд хамруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.

Үүнтэй холбоотойгоор Нийгмийн халамжийн тухай хуулийн 8.2.8-д "Нийгмийн халамжийн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх судалгаа, шинжилгээ, үнэлгээний зардал" гэж заасны дагуу 577.6 сая төгрөг төсөвлөв.

1.1.2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэн, чанар, үр ашгийг дээшлүүлж тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэх нөхцөл

боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой.

2001 оноос "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай" хууль, "Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай" хууль хэрэгжиж эхэлснээр хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлэх эрх зүй, эдийн засгийн орчин бүрдсэн. Улмаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг байгуулж, Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаад иргэдийн ажлын байрны төлбөрөөс сангийн үндсэн орлогыг бүрдүүлж байна. Тус сан нь орлогоороо зарлагаа нөхөх зарчим баримтлан ажиллаж байгаа ба хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулагдаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор 2025 онд хэрэгжүүлэхээр "Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа", "Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа", "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", "Түр ажлын байраар хангах болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа", "Засгийн газар, ХЭҮЗ-ийн шийдвэрээр тодорхойлогдсон хөтөлбөр төсөл", жижиг зээл зэрэг хөтөлбөр үйл ажиллагаанууд батлагдсан байна.

Хөтөлбөрийн хүрээнд залуучуудын, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас гадна ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүдийг хөдөлмөрт бэлтгэх, ажлын байраар хангах, үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй эрхлэгчдэд үйл ажиллагаа сэргээхэд чиглэсэн хүүгүй, барьцаагүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж байнгын болон түр ажлын байр бий болгох, хадгалах зорилгоор санхүүжүүлэн хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Мөн энэ онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд үнэлгээ хийж хөдөлмөр эрхлэлт, гүйцэтгэл, үр дүнд анхаарч хөдөлмөр эрхлэх сонирхолтой иргэдийг түлхүү хамруулахаар төлөвлөсөн.

Эх үүсвэр:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2026 оны орлогын эх үүсвэрийг 117.9 тэрбум төгрөг байхаар тооцон 2026 оны төсвийн санал хүргүүлж байна. Үүнд:

a) 2026 онд ажлын байрны төлбөрийн орлого буюу үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих орлого **30.8 тэрбум төгрөг;**

b) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн эх үүсвэрийг **18.9 тэрбум төгрөг;**

c) Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр **3.9 тэрбум төгрөг**; Хөдөлмөрийн тухай хуулийн 144.1, 144.2, 144.3-дахь заалтын хүрээнд "..... хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлөх" гэж зааснаар аж ахуй нэгжүүдээс 2024 онд төлбөр төлсөн орлогын гүйцэтгэлийг харгалзан Хөдөлмөрийн тухай хуулийн 144.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг гэрээгээр байнга худалдан авах зэргээр тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн ажил олгогчийг энэ хуулийн 144.3-т заасан төлбөрөөс чөлөөлж, эсхүл хөнгөлж болно"

d) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үлдэгдлийг Сангийн яаманд татан төвлөрүүлсэн шилжүүлгийн 140.4 тэрбум төгрөгийг 2026 онд буцааж авахаар тооцсон ба үүнээс 2026 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт **64.3 тэрбум төгрөг** санхүүжүүлэх санал боловсруулаа.

Зарлага.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2026 оны нийт зарлагын хэмжээ 129.9 тэрбум төгрөгөөр, 152,0 орчим мянган иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил, жижиг аж ахуйн нэгжийг хөтөлбөр, арга хэмжээнд хамруулахаар тооцлоо.Үүнд:

a) Дотоод эх үүсвэрээс олгох зээл **35.0 тэрбум төгрө**г: Арилжааны банкаар дамжуулан олгодог жижиг зээлийг Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-д заасны дагуу хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, бичил үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэдийг дэмжих арга хэмжээг түлхүү хэрэгжүүлэх, энэхүү арга хэмжээг төсөл, хөтөлбөр хэлбэрээр зохион байгуулж байгаа бөгөөд 2025 онд 45.0 тэр бум төгрөг санхүүжүүлэх төсөв батлагдсан боловч хүлээгдэж буй гүйцэтгэл бага байгаа тул 2026 онд мөн 10.0 тэрбум төгрөгөөр бууруулсан;

b) Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг **41.2 тэрбум төгрөг:** Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт тусгасан Хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил бизнес эрхлэгчдийг зээлийн бодлогоор дэмжих, жижиг зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, жижиг зээл олгох үйл ажиллагааг зохион байгуулах байгууллагын төвлөрөл, шат дамжлагыг бууруулах чиглэлээр Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-д 2025 оны 05 дугаар сарын 28-ны 267 дугаар тогтоолоор өөрчлөлт орж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох санхүүгийн дэмжлэгийн мөнгөн дүнгийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг 2026 онд өмнөх оноос **4.1 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлсэн;

c) Бусад хөтөлбөр, арга хэмжээний зардлыг өмнөх оны түвшингээр тооцсон.

1.1.3. ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ САН:

Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3 дахь заалтад 2021 онд нэмэлт, өөрчлөлт орсноор хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт, хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоог дэмжих зориулалт бүхий "Хүүхдийн төлөө сан" байгуулагдан, сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 139 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журамд сангийн хөрөнгийн санхүүжилтээр дэмжих хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг илүү тодорхой болгож, сангийн хөрөнгийг дараах зориулалтаар зарцуулахаар тусгасан. Үүнд:

- Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг дэмжих;
  - Хүүхдэд зориулсан барилга байгууламж шинээр барих;
  - Хүүхдэд зориулсан барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх;
  - Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах.
- Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцож амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах;

- Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд зааснаар хүүхдийн төлөө сангийн хөрөнгө нь улсын төсөв, хандив, тусламж, авто тээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлого, хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг дэмжсэн соёл, урлаг, спортын тоглолтын хандив, тусламжийн орлогоос бүрдэнэ.

Хүүхдийн төлөө сангийн орлого: Авто тээврийн үндэсний төвийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогоос 2022 онд 4,395.1 сая төгрөг, 2023 онд 5,008.7 сая төгрөг, 2024 онд 10,092.1 сая төгрөг, иргэн аж, ахуйн нэгж байгууллагаас 2022 онд 5.0 сая төгрөг, 2023 онд 0.1 сая төгрөг, 2024 онд 0.3 сая төгрөг тус тус төвлөрүүлээд байна.

Зарцуулалт: Тус сангаас 2022-2024 онд нийт 276 хүүхдэд 671.0 сая төгрөгийн дараах дэмжлэг, урамшуулал олгосон.

- Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд амжилт гаргасан хүүхдийн урамшуулалд 2022 онд 30 хүүхдэд 81.7 сая төгрөг, 2023 онд 147 хүүхдэд 300.0 сая төгрөг, 2024 онд 92 хүүхдэд 248.9 сая төгрөг;
- Тэмцээн, уралдаанд оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх дэмжлэгт 2023 онд 5 хүүхдэд 28.6 сая төгрөг, 2024 онд 2 хүүхдэд 11.8 сая төгрөг тус тус зарцуулж 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 24,340.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт 2024 онд хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын 5 төсөл, арга хэмжээний санал ирсэн боловч ажлын хэсэг хууль, журамд заасан шаардлагад нийцээгүй гэж үзэн татгалзаж, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөс “хүүхдийн авто замын танин мэдэхүйн байгууламж” төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэн, сонгон шалгаруулалт зарласан. Тус тендер шалгаруулалтад үнийн санал ирээгүй тул амжилтгүй болж, хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ цуцлагдан, тус зориулалтаар гүйцэтгэл гараагүй байна.

Хүүхдийн төлөө сангийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2026 оны төсвийн санал:

2025 оны хагас жилийн байдлаар Авто тээврийн үндэсний төвийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогоос 1,840.3 сая төгрөг, иргэн, иргэн аж ахуйн нэгж, байгууллагын хандит 0.3 сая төгрөг төвлөрч, олон улсын уралдаан, тэмцээнд амжилт гаргасан 21 хүүхдэд 40.6 сая төгрөгийн урамшуулал, тэмцээн, уралдаанд оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй 9 хүүхдэд 45.9 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг олгоод байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт 2025 онд Хүүхдийн төлөө зөвлөлүүдээс хүүхдэд зориулан шинээр барьж байгуулах, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний 30 гаруй санал ирсэн. “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын дагуу төсөл, арга хэмжээний саналуудыг хянан 2025 оны батлагдсан төсөвт нийцүүлэн дараах 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр сонгож Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд танилцуулан, шийдвэрийг хүлээж байгаа тул одоогоор тус арга хэмжээнд төсөв зарцуулагдаагүй байна.

Хүүхдийн төлөө сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт: /сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эдийн засгийн ангилал	Төсөвт өртөг			
			Нийт төсөвт өртөг	2025 оны төсөвт өртөг	2026 оны төсөвт өртөг	2027 оны төсөвт өртөг
1	Өвөржаргалант хүүхдийн зуслангийн гадна цахилгаан хангамжийн ажил (Баянхонгор, Эрдэнэцогт сум)	Барилга байгуулламж	1,589.3	400.0	594.7	594.7
2	Гэр бүл, хүүхэд, залуучуудын ордон (Говьсүмбэр, Сүмбэр сум)	Барилга байгуулламж	4,525.1	1,100.0	1,712.6	1,712.6
3	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асран хамгаалагчдад үйлчлэх төвийн барилга (Дорноговь, Сайншанд сум)	Барилга байгуулламж	4,587.5	1,100.0	1,743.8	1,743.8
4	Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Задгай талбай, хөлбөмбөгийн талбайн шинэчлэл (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг)	Их засвар	1,489.0	473.9	507.6	507.6
5	Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Зуны хоолны газар засвар шинэчлэл (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг)	Их засвар	798.0	798.0	-	-
6	Хүүхдийн ордны тоног төхөөрөмж (Архангай, Цэцэрлэг сум)	Тоног төхөөрөмж	230.0	230.0	-	-
7	Нөхөн сэргээх, хүүхэд хөгжил, сургалтын төвийн тоног төхөөрөмж /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	Тоног төхөөрөмж	214.0	214.0	-	-
8	Хүүхдийн өвчлөлийн оношлогоо, эрт илрүүлэг, эмчилгээнд нэн шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн жагсаалт (Улаанбаатар)	Тоног төхөөрөмж	4,482.2	3,500.0	982.2	-
	НИЙТ ДҮН		**17,915.1**	**7,815.9**	**5,540.7**	**4,558.5**

Хүүхдийн төлөө сангийн 2026 оны төсвийн төсөлд хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын санхүүжилтийг батлагдсан төсвийн хязгаараас нэмэгдүүлэлгүй 8,315.9 сая төгрөгөөр төсөвлөснөөр сангийн үлдэгдлийг ***21,405.0 сая*** төгрөгөөр тооцлоо.

Хүүхдийн төлөө сангийн 2025 оны ХБГ, 2026 оны төсвийн төслийн санал: /сая.төг/

Үзүүлэлт		2025 он		2026 он
		Төсөв	ХБГүй.	Төсвийн санал
Сангийн зарлага		**8,315.9**	**8,315.9**	**8,315.9**
Үүнээс:	Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих	7,815.9	7,815.9	7,815.9
	Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах;	500.0	500.0	500.0
	Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх			
Сангийн орлого			**6,497.1**	**7,199.1**
Үүнээс:	Автотээврийн үндэсний төв		6,496.8	7,199.1
	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хандив		0.3	
Сангийн эцсийн үлдэгдэл			**22,521.8**	**21,405.0**

---oOo—

1.2. ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН САНАЛ

1.2.1. ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний салбар нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, төрийн үйлчилгээг иргэд, үйлчлүүлэгчдэд хуулийн дагуу, шуурхай, мэргэжлийн түвшинд үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллага юм.

Энэ чиг үүргийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд, Ахмад настны үндэсний төв, БНСУ дах Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв гэсэн 32 нэгжээр дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний салбарын 32 нэгж, байгууллагын үйл ажиллагааны зардалд 2026 онд 79,190.8 сая төгрөгөөр тооцон 2025 оны батлагдсан төсвөөс 4,320.5 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн нь 2025 оны төсвийн тодотголоор төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын тоог бууруулахтай холбогдуулан орон тоо, цалин, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал болон урсгал зардал буурсантай холбтоотой байна.

Цалингийн сан, орон тоо:

Салбарын цалин, нэмэгдэл, урамшуулал, унаа хоолны зардлыг одоо мөрдөж байгаа тогтоол, шийдвэрийн хүрээнд тооцон төлөвлөсөн бөгөөд орон тоог төсвийн хязгаараас 45 орон тоогоор нэмэгдүүлэн тооцов. Үүнд:

- Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 96 дугаар тогтоолоор Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газрын чиг үүргийг төрийн захиргааны болон харьяа дүүргийн холбогдох байгууллагад шилжүүлсэн, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын бүтэц орон тоог 19 орон тоо нэмэгдүүлж 91 орон тоотой байхаар тогтоосон боловч 2025 оны төсвийн тодотголоор төрийн албан хаагчийн орон тоог 9 хувиар бууруулах шийдвэрийн хүрээнд 83 орон тоогоор ажиллаж байгаа боловч 2026 оны төсвийн хязгаар батлахдаа 66 орон тоогоор баталсан. Иймд 2026 онд 2025 онд ажиллаж байсан орон тоог 9 хувиар бууруулан 83 орон тоотой ажиллахаар төсөвлөсөн.
- Мөн Баянзүрх дүүргийн ХХҮХэлтэс 2025 онд 86 орон тоогоор ажиллаж байсан бөгөөд төрийн албан хаагчийн орон тоог 9 хувиар бууруулах шийдвэрийн хүрээнд 8 орон тоогоор бууруулж 78 орон тоогоор ажиллаж байгаа боловч төсвийн хязгаар батлахдаа 71 орон тоогоор баталсан нь Хөдөлмөр эрхлэлтийн албаны 7 орон тоог орхигдуулсан байна.
- Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/12 дугаар захирамжаар Хүмүүнлэгийн ордон буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг тус газрын харьяанд шилжүүлсэнтэй холбогдуулан 7 орон тоо нэмэгдүүлэх, мөн байр ашиглалтын болон бусад үйл ажиллагааны зардал нэмэгдүүлсэн;
- Өмнөговь аймгийн ХХҮГ-ийн дэргэд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа сувиллын барилга 2025 оны 10 дугаар сард ашиглалтад орох тул жижүүр, үйлчлэгч, угтах үйлчилгээний ажилтан нийт 4 орон тоо нэмэгдүүлсэн;

Унаа хоолны хөнгөлөлт:

Төсөвт байгууллагын унаа, хоолны зардлыг нэг жишгээр тооцож, батлах шаардлагатай байна. Орон тооны хэмнэлтээс шалтгаалсан цалингийн хэмнэлтээс шалтгаалан газар, хэлтэс бүр өөр дүнгээр унаа, хоолны хөнгөлөлтийг олгож байна.

Тус зардлыг хөдөө орон нутагт 25.0, хотын дүүргүүдийг 30.0 мянган төгрөгөөр тооцож 10,225.3 сая төгрөгөөр;

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал:

Түлш халаалтын зардлыг 2025 онд нэмэгдүүлсэн болон 2 аймагт барилга нэмэгдсэнтэй холбогдуулан 401.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тооцсон.

- Баянхонгор аймгийн ХХҮГ-т Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/12 дугаар захирамжаар Хүмүүнлэгийн ордон буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийг тус газрын харьяанд шилжүүлсэнтэй холбоотой байр ашиглалтын зардал.
- Өмнөговь аймгийн ХХҮГ-ийн дэргэд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа сувиллын барилга 2025 оны 10 дугаар сард ашиглалтад орох тул байр ашиглалтын зардлыг тооцон нэмэгдүүлсэн.

Хангамж бараа материалын зардал:

Тус салбарын хувьд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээг үзүүлэхэд бичиг цаасны хэрэглээ зайлшгүй шаардлагатай анхан шатны баримт материалыг журмын дагуу бүрдүүлэх, архивын нэгж үүсгэж хадгалахаар заасан байдаг, мөн жилээс жилд хэрэглээний үнийн өсөлттэй уялдан бичиг хэргийн зардал хэд дахин өссөөр байгаа тул батлагдсан бичиг хэргийн зардал хүрэлцэхгүй өглөг үүсээд байна.

Мөн 2023 онд Мэргэжлийн хяналтын газраас 106 орон тоо нэмэгдэж ирсэнтэй холбоотой тэдгээр ажилчдын бичиг хэргийн зардал /акт, албан шаардлага, шалгалтын тэмдэглэл, улсын байцаагчийн дүгнэлт, албан бланк, тайлан зэргийг нь бүгд цаасаар баталгаажуулахыг хуулиар заасан байдаг тул тээвэр шатахуун, шуудан холбоо, БҮТЭЗ-ийн зардал нэмэгдэж байна.

Норматив зардал:

Энэ бүлгийн зардалд хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газруудын дэргэдэх Ахмадын асрамж, Ахмадын амралт, сувиллын үйл ажиллагаатай холбоотой зардлууд батлагддаг.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.13. “Энэ хуулийн 19.5.1-д заасан нэг хүнд ногдох зардлын нормативыг байнгын асаргаа шаардлагатай иргэнд 3 дахин нэмэгдүүлэн тооцно” гэж нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан Ахмад настны үндэсний төв болон бүсийн асрамжийн төвүүдийн норматив зардал нэмэгдсэн.

Ахмадын амралт сувилал ХНХСайдын 2013.07.10-ны өдрийн А/110 тоот тушаал, ХХҮЕГ-ын 2016.03.11-ний өдрийн 4/282 тоот албан бичгээр ахмад настны хувь хүний төлөх төлбөрийг 8.0 мянган төгрөгөөр, ЗГ-ын 2024 оны 159 дүгээр тогтоолоор Нийгмийн халамжийн сангаас олгох хөнгөлөлтийг 35.0 мянган төгрөгөөр тооцон туслах үйл ажиллагааны өөрийн орлогоор санхүүжиж үйл ажиллагаагаа явуулж байна.

Эд хогшил, урсгал засварын зардал:

Тус зардалд Мэргэжлийн хяналтын албан хаагчдын албан хэрэгцээнд шаардагдах багаж, ажлын хувцас хамгаалах хэрэгслийн зардал, газар хэлтсийн зайлшгүй шаардагдах цөөн тооны тоног төхөөрөмжийн зардал тусгагдсан. Урсгал засварын зардлын ангилалд автомашины засвар үйлчилгээ, газар хэлтсийн байр ашиглалттай холбоотой жижиг хэмжээний урсгал засварын зардал тусгагдсан.

Дотоод албан томилолтын зардал: Мэргэжлийн хяналтын албан хаагчид үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, ослын дуудлага, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын жилийн батлагдсан төлөвлөгөөний дагуу хийхэд шаардагдах томилолтын зардал;

ХХҮЕГ болон харьяа хэлтсүүдийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой орон нутагт хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт болон нийгмийн халамжийн үйлчилгээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлээ болон дотоод хяналт шалгалт хийхэд зайлшгүй шаардагдах томилолтын зардал;

ХХҮЕГ-ын Гадаад ажилтан илгээхтэй холбоотой хүргэлтийн ажилтны томилолтын зардал, анхан шатны нэгжид ажиллаж буй сумын мэргэжилтэн солигдох, аялаас гарахад ажил хүлээлцэх зэрэг зайлшгүй албан томилолтоор ажиллах шаардлагатай байдаг.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж:

Тус зардалд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын гадаадад ажиллах хүч илгээхтэй холбоотой зарцуулагдах зардал, газар хэлтсүүдийн ахмадын сувиллын ажилтан албан хаагчдын цалин, мөн салбарын бүх газар хэлтсийн холбооны суваг ашигласны төлбөр буюу интернет үйлчилгээний зардал, Солонгосын ХНХҮТөвийн албан хаагчдын даатгалын төлбөр, бусад газар хэлтсийн төлбөр хураамжтай холбоотой зардал, аудитын төлбөрийн зардал зэрэг тусгагддаг.

Ажил олгогчоос олгох нэг удаагийн буцалтгүй тусламж:

- Салбарын хэмжээнд төрийн албаны тухай хуулийн 46.2.2 дах заалтын хүрээнд тэтгэвэрт гарах 31 албан хаагчийн 917.9 сая төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 65 албан хаагчид 526.6 сая төгрөг тус тус төсөвлөж өмнөх оноос , нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулалд 173.4 сая төгрөг, нийт 1,617.9 сая төгрөгөөр тус тус төлөвлөв.
- БНСУ дахт ХНХҮТ-ийн албан хаагчид нь түрээсийн байранд амьдардаг бөгөөд түрээсийн зардалд сард 800.0-1,300.0 мянган воныг цалингийн орлогоос төлдөг. Төрийн албаны тухай хууль, төвийн дотоод журмыг үндэслэн ажилтныг орон байраар хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор сар бүр 1,000.0 мянган воны байрны түрээсийн зардлын дэмжлэг олгохоор 748,8.0 сая төгрөгийг бусад тусламж, дэмжлэгийн зардалд төсөвлөсөн.

1.2.2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД

Нийгмийн даатгалын салбарын 2026 оны төсвийн төслийн саналыг 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг үндэслэн ***66,519.6 сая*** төгрөгөөр, үүнээс бараа үйлчилгээний зардлыг 65,147.2 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 1,372.5 сая төгрөгөөр тус тус төлөвлөлөө.

Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн 2026 оны төсвийн төслийн саналыг одоогийн мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд дараах байдлаар тооцов. Үүнд:

Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллын талаар:

Нийгмийн даатгалын байгууллагууд нь 2025 онд Засгийн газрын 2024 оны “Төсвийн төвлөрүүлэн захирагчийг шинэчлэн батлах тухай” 110 дугаар тогтоол, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны “Нийгмийн даатгалын төв болон орон нутгийн байгууллагын орон тооны хязгаарыг батлах тухай” А/45 дугаар тушаалаар баталсан орон тооны дагуу 1,477 ажилтан, албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2026 онд Засгийн газрын төрийн байгууллагын орон тоог бууруулах, төрийн байгууллагын ажлын чиг үүрэг, давхардлыг багасгах зорилтын хүрээнд 136 орон тоо бууруулж нийт 1,341 орон тоотой ажиллахаар төлөвлөлөө.

Дээрх бүтцийн өөрчлөлт, орон тоог харгалзан Засгийн газрын 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 487 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолыг үндэслэн харьяа байгууллагуудын цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг ***53,445.7*** сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийг ***6,705.9 сая*** төгрөгөөр төсөвлөсөн.

Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын дагуу үндсэн цалинг, Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 382 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны "Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 489 дүгээр тогтоол, Улсын Их Хурлын 2019 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" 21 дүгээр тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу олгох нэмэгдлүүдийг тооцсон.

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйл болон Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д заасны дагуу ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн хагас, бүтэн жилээр олгох мөнгөн урамшуулал, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдэд олгох цагийн хөлсийг тооцсоноор урамшууллын зардалд нийт 6,868.0 сая төгрөгөөр тус тус төсөвлөлөө.

Унаа, хоолны хөнгөлөлтийг хөдөө, орон нутагт 15,000 төгрөг, нийслэлд 25,000 төгрөг болгон нэмэгдүүлж тооцсоноор салбарын хэмжээнд 6,174.0 сая төгрөг төсөвлөгдлөө.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын талаар:

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024, 2025 оны "Тариф батлах тухай" тогтоолууд, аймаг, нийслэлийн дулааны эрчим хүчээр хангах, худалдан авах гэрээний дагуу байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг хянаж 2026 онд тус зардлыг ***1,959.4 сая*** төгрөгөөр тооцов. Байр ашиглалтын зардлын нэмэгдлийн 91.3 хувь нь түлш, халаалтын зардлын нэмэгдэл байгаа бөгөөд энэ нь тус зардлын 2026 оны хязгаар 2025 оны батлагдсан төсвөөс буурч батлагдсантай холбоотой байна.

Хангамж, бараа материалын зардал:

Нийгмийн даатгалын салбар нь даатгуулагчдын тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтын хуудсыг хүн бүрээр хэвлэх, мөн архивын цаасан суурьтай хадгаламжийн нэгж бүрдүүлдэг тул өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад бичиг хэргийн зардлын төсөв хүрэлцэхгүй хүндрэл бэрхшээл үүсч байгаа боловч 2026 оны батлагдсан хязгаарын түвшинд буюу 193.3 сая төгрөгөөр төсөвлөсөн.

Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс болон шуудан холбоо, интернэтийн зардал нь жилээс жилд нэмэгдэж уг зардлын төсөв хүрэлцэхгүй байгаа талаар нийгмийн даатгалын байгууллагуудаас албан бичиг, тооцоо судалгааг байнга ирүүлж байна. Иймд 2026 оны хангамж, бараа материалын зардлын төсвийг батлагдсан төсвийн хязгаараас 174.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн ***747.7 сая*** төгрөгөөр тооцов.

Эд хогшил, урсгал засварын зардал:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийгмийн даатгалын байгууллагуудад сүүлийн жилүүдэд ажилтан, албан хаагчдын албан хэрэгцээний тавилга, эд хогшлын зардал, их засварын зардал төсөвлөгдөөгүйгээс урсгал засвар, багаж, техник хэрэгслийн зардал зайлшгүй тусгах шаардлагатай байна.

Иймд салбарын хэмжээнд байцаагч, ажилтнуудын албан хэрэгцээний багаж, техник хэрэгслээр үе шаттайгаар хангах, шинэчлэх зорилгоор 2026 онд багаж, техник хэрэгслийн

зардлыг 63.0 сая төгрөгөөр, урсгал засварын зардлыг 305.4 сая төгрөгөөр, хөдөлмөр, хамгааллын хэрэгслийн зардлыг 35.7 сая төгрөгөөр тус тус тооцсоноор тус ангилалд ***404.1 сая*** төгрөг тусгахаар төсөвлөлөө.

Томилолтын зардал:

Байгууллагын болон нийгмийн хамгааллын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардагдах дотоод албан томилолтын зардлыг Сангийн сайдын 2024 оны "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээг үндэслэн ***237.7 сая*** төгрөгөөр тооцов.

2025 онд салбарын хэмжээнд хэрэгжүүлсэн мэдээллийн технологийн үйлчилгээний зардлыг 2026 оны төсвийн төсөлд тусгаагүй тул ***бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал*** батлагдсан төсвийн хязгаараас 6,197.1 сая төгрөгөөр буурч ***1,600.8 сая*** төгрөг төсөвлөгдсөн. Нийгмийн даатгалын байгууллагуудын ажилтан албан хаагчдад ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд зохион байгуулах хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардалд ***45.8*** **сая** төгрөг төсөвлөсөн.

Бусад урсгал шилжүүлгийн зардал:

2026 онд өндөр насны тэтгэвэрт гарах 28 албан хаагчид олгох 1,009.9 сая төгрөг, Төрийн албаны тухай хуулийн дагуу 28 албан хаагчид олгох "Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчийн урамшуулал"-д 270.3 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардалд 92.3 сая төгрөг, нийт ***1,372.5 сая*** төгрөгийг тус зардалд төсөвлөлөө.

1.2.3. ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын салбарын 2026 оны төсвийн төслийн саналд бараа, үйлчилгээний зардалд 61,524.3 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 718.2 сая төгрөг, нийт урсгал зардалд **62,242.5 сая** төгрөг зарцуулахаар тусгалаа.

2026 онд Засгийн газрын бодлогын хүрээнд тус салбараас 101 орон тоо бууруулан 1,011 орон тоотой ажиллахаар тооцон нийт албан хаагчдын ***цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын*** зардлыг ***42,586.8 сая*** төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг ***5,284.0 сая төгрөгөөр*** төлөвлөв. Шинээр ашиглалтад орж буй Архангай, Баян-Өлгий, Сэлэнгэ аймгийн "Хүүхдийн хөгжил, хамгааллын ордон"-уудад ажиллах 36 албан хаагч, 2026 онд ашиглалтад орж "ОУ-н хүүхдийн Найрамдал" зуслангийн салбар зуслангаар үйл ажиллагаа явуулах "Сүхбаатар дүүргийн хүүхэд, залуучуудын ногоон бүсийн зуслан"-д ажиллах 53 албан хаагчийн цалин, НДШ-ийг тооцон шинэ хөрөнгө оруулалттай холбоотой урсгал зардлын саналд тусган хүргүүллээ. Мөн Засгийн газрын 2024 оны 237 дугаар тогтоолоор салбарт нэмэгдсэн 758 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудын орон тоо, үндсэн цалин түүнтэй холбогдох ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг тооцоод байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2026 оны батлагдсан төсвийн хязгаараас 1,619.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, **6,401.4 сая** төгрөгөөр төсөвлөө. Энэ нь Архангай аймгийн ХГБХХГ-т орон нутгийн өмчөөс шилжиж буй Хүүхдийн ордон, 2026 оны 01 дүгээр сараас ашиглалтад орох Баян-Өлгий аймгийн ХГБХХГазрын харьяа "Хүүхдийн хөгжил хамгааллын ордон", "Сүхбаатар дүүргийн хүүхэд, залуучуудын ногоон бүсийн зуслан"–ийн ашиглалтын зардлыг нэмж тооцсонтой холбоотой.

Салбарын хэмжээнд дутагдаж буй тээвэр шатахуун, шуудан холбоо, интернетийн төлбөрийн зардлыг байгууллагуудын хэрэгцээ, шаардлагад үндэслэн нэмэгдүүлж хянаснаар ***хангамж, бараа материалын болон норматив зардал*** 2025 оны батлагдсан төсвийн хязгаараас 409.0 сая төгрөгөөр нэмэгдэж ***5,243.1 сая*** төгрөгөөр төсөвлөгдөж байна.

Эд хогшил, урсгал засварын зардалд аймгуудын түр хамгаалах байр, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байрны ажилчдын аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд хөдөлмөр хамгааллын хэрэглэл болон шаардлагатай багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлыг тусгаснаар тус зардал ***643.9 сая*** төгрөгөөр тусгагдсан.

Байгууллагын дотоод албан томилолтын болон хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай ***дотоод албан томилолтын зардлыг*** Сангийн сайдын 2024 оны "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээг үндэслэн ***141.7 сая*** төгрөгөөр тооцов.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг батлагдсан төсвийн хязгаараас 2,855.8 сая төгрөгөөр бууруулж ***955.3 сая*** төгрөгөөр төсөвлөсөн нь сум, хороодод ажиллаж буй нийгмийн ажилтнуудын цалинг тус эдийн засгийн ангиллаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлуудад шилжүүлэн төсөвлөсөнтэй холбоотой. 2026 онд тус зардалд Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байрын харуул хамгаалалтын зардалд 150.0 сая төгрөг нэмж тусгасан.

Бараа үйлчилгээний бусад зардлыг батлагдсан төсвийн хязгаараас 72.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж ***268.0 сая*** төгрөгөөр төсөвлөлөө. Тус зардалд хууль тогтоомж, эрхзүйн бусад шийдвэрийн хүрээнд зөвшөөрөгдсөн, ажил үйлчилгээ үзүүлэгчид төлөх ёстой төлбөр хураамжууд, байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд жил бүр албан хаагчдыг мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах, дадлага сургуулилт хийлгэх зорилгоор дотоодод сургалтад хамруулахад зардлыг төсөвлөсөн.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын байгууллагын ***бусад урсгал шилжүүлгийн зардалд*** холбогдох хууль тогтоомжид заасны дагуу 2026 онд өндөр насны тэтгэвэрт гарах 20 албан хаагчид олгох 567.5 сая төгрөг, Төрийн албаны тухай хуулийн дагуу 6 албан хаагчид олгох "Хөдөө орон нутагт тогтвор сууршилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчийн урамшуулал" 54.1 сая төгрөг, салбарын нийт албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардалд 96.7 сая төгрөг, нийт ***718.2 сая*** төгрөг тусгалаа.

ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай, Хөдөлмөрийн тухай хуулт болон хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч үзүүлэх үйлчилгээ, бусад харилцааг зохицуулсан 50 гаруй дүрэм, журам, стандарт, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллахад тус зардлыг төлөвлөн зарцуулдаг.

Тус хөтөлбөрийн төсвийн төслийн саналыг Засгийн газрын 2024 оны 236 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, норматив"-ын дагуу статистик тоон мэдээнд тулгуурлан ***20,515.2 сая*** төгрөгөөр тооцож байгаа бөгөөд 15,692.8 сая төгрөгийг төсвийн хязгаарт багтааж, 4,822.3 сая төгрөгийг үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн тооны өсөлттэй уялдуулан нэмж төлөвлөлөө.

Нийт хүүхэд хамгааллын төсвийн 7.3 хувийг эрсдэлийн болон НБҮ хийх, хамтарсан багийн урамшуулал олгоход, 51.2 хувийг хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардалд,

24.1 хувийг урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд, 17.4 хувийг хөгжил оролцоо арга хэмжээнд тус тус төлөвлөлөө.

Шуурхай тусламжийн үйлчилгээний зардал буюу эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх зардалд 1,139.5 сая төгрөг төсөвлөсөн. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 14.1.6, Хүүхдийн эрхийн мэдээллийн сан бүрдүүлэх журмын хэрэгжилтийг ханган ажиллаж, эрсдэлийн программд бүртгэлтэй хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж хүүхдийн хамгаалуулах, эсэн мэнд амьдрах, боловсрол эзэмших, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангаж, хоёрдогч эрсдлээс урьдчилан сэргийлж ажилладаг. Сүүлийн 5 жилээр авч үзвэл: 2018 онд 19,058 хүүхэд, 2019 онд 13,468 хүүхэд, 2020 онд 22,756 хүүхэд, 2021 онд 20,724 хүүхэд, 2022 онд 14,207 хүүхэд, 2023 онд 15,905 хүүхэд, 2024 онд 10,812 хүүхэд хамгааллын үйлчилгээ авч бүртгэгдсэн байна. Хүүхдийн тусламжийн 108 утсанд 2024 онд ирсэн нийт 101,321 дуудлагаас хүүхэд хамгааллын дуудлагын тоо 10,812 бүртгэгдсэн нь өмнөх оноос 8.9 хувиар, хүүхдийн эрхийн зөрчлийн дуудлагын тоо 13,164 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 9.6 хувиар буурсан.

Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэгчийн тоо 7.1 хувиар буурсан байна. 2024 онд кейс шийдвэрлэлт 87.4 хувьтай, хяналтын дуудлага 12.6 хувьтай байна. 2024 онд эрсдэлт нөхцөлд байгаа 12,941 хүүхэд, гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээ, шаардлагатай тусламж, дэмжлэг үзүүлсэн байна.

2026 онд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлтийг сайжруулж, мэдээллийн санд бүртгэн, хүүхэд тэдний гэр бүлийг дэмжих үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх, хяналтыг тогтмолжуулж нийт 16,186 хүүхдэд шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд 1,139.5 сая төгрөг зарцуулахаар тооцлоо.

Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардалд 8,039.5 сая төгрөг тооцсон. Хүүхдийн асрамж, халамжийн төвд асран хамгаалуулж байгаа 893, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлж, аюулгүй байдлын хамгаалалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан 3,073 хүүхэд байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон 2,860 хүүхэд, хүүхэд оролцсон гэмт хэрэг 1,373, гэмт хэрэгт холбогдсон 1,675 хүүхэд, гэмт хэргийн улмаас хохирч амь насаа алдсан 111, бэлгийн хүчирхийллийн хохирогч 371 хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 371 хүүхэд, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороогоор үйлчлүүлсэн 1,758 хүүхэд, хүүхдийн эрхийн зөрчил 139, хөдөлмөр эрхлэгч хүүхэд 410, хараа хяналтгүй хүүхэд 240, хамтарсан багийн үйлчилгээ авсан 6,095 хүүхэд байна.

Хамгаалах нөхөн сэргээх түвшний үйлчилгээг гэр бүлийн орчинд болон гэр бүлээс тусдаа орчинд үзүүлж байгаа бөгөөд 2024 онд 7,630.8 сая төгрөгийг зарцуулсан ба 1 хүүхдэд дунджаар 2024 онд 277.9 мянган төгрөг зарцуулсан байна. 2026 онд нийт 16,186 хүүхдэд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхээр норматив зардалд 3,688.4 сая төгрөг 13,235 хүүхдэд төлбөртэй тусламж үйлчилгээ үзүүлэхэд 2,808.1 сая төгрөг /1 хүүхдэд дунджаар 187.0 мянган төгрөг/, хоолны зардалд нийт 1,543.0 сая төгрөг нийт 8,039.5 сая төгрөгийг бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажиллах, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа, 108, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн үйл ажиллагаа, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хараа хяналтгүй хүүхдэд чиглэсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ, хамтарсан багийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ зэрэгт зарцуулахаар тооцож холбогдох зардлуудад тусгалаа. Өмнөх оны төсвөөс буурсан шалтгаан нь хүүхдийн асрамж халамжийн төвийн хүүхдийн хоолны хувьсах зардлыг Нийгмийн халамжийн тухай хуулиар Нийгмийн халамжийн сангаас олгохоор төсөвлөсөнтэй холбоотой.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 3,775.7 сая төгрөг зарцуулахаар тооцсон. 2025 онд хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээ, арга хэмжээнд нийт хүүхдийн 70.0 хувийг хамруулахаар төлөвлөсөн бөгөөд 2026 онд хамрагдалтыг 75 хувь хүргэхэд 5,108.4 сая төгрөг шаардлагатай боловч батлагдсан төсвийн хязгаарт нийцүүлэн ***3,775.7 сая*** төгрөг төсөвлөлөө. Иймд тус зардалд хамрагдах хүүхдийн тоо буурч нийт хүүхдийн 55.4 хувь буюу 704.8 мянган хүүхэд тус арга хэмжээнд хамрагдахаар байна.

2026 оны зарцуулахаар төсөвлөсөн нийт зардлын 1,476.8 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний зардалд, 2,298.9 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд тус тус зарцуулна.

Хүүхдийн хөгжил оролцооны зардалд 2,738.2 сая төгрөг төсөвлөлөө.

Үндэсний хэмжээнд сүүлийн 3 жилд 15 хүүхдийн ордон, 6 хөгжлийн төв, 4 хүүхдийн театр болон сургууль, бусад гэсэн 5 үзүүлэлтээр хүүхэд хөгжлийн үйлчилгээнд 2024 онд давхардсан тоогоор ***376,299*** хүүхэд хамрагдсан байна. Үүнээс хүүхдийн ордноор 42,270 хүүхэд, сургуулиар 172,603 хүүхэд, хөгжлийн төвөөр 26,736 хүүхэд, хүүхдийн театраар 23,868, бусад байгууллагаар 110,822 хүүхэд хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан.

Хүүхдийн хөгжил оролцооны зардлын зориулалт нь 2025 оноос хүүхэд, хөгжил хамгааллын үйлчилгээний төсөвт шинээр орж, салбарын хэмжээнд 4,900.0 сая төгрөг батлагдсан. Үүнээс зуслангийн үйл ажиллагаанд 6,360 хүүхэд хамруулахаар 1,800.0 сая төгрөг, 3,100.0 сая төгрөгийг хүүхдийн хөгжил, бие махбодын хөгжлийг дэмжих үйлчилгээ, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ, хүүхдийн оролцоог дэмжих үйл ажиллагаанд зарцуулж байна.

2026 онд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар нь Хүүхдийн хөгжил оролцоог дэмжих үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон ажиллах бөгөөд тус арга хэмжээнд хамрагдах хүүхдийн тоог өмнөх жилүүдээс нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсролын сайд, Сангийн сайдын хамтарсан "Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал"-ыг шинээр боловсруулж батлуулахаар ажиллаж байна. Тус арга хэмжээнд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлж, аргачлалын дагуу хүүхдийн хөгжил, оролцооны арга хэмжээг санхүүжүүлэхэд 7,092.0 сая төгрөг нэмж тусгах шаардлагатай боловч батлагдсан төсвийн хязгаарт нийцүүлэн ***2,738.2 сая*** төгрөг төсөвлөлөө.

ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ ХӨТӨЛБӨР

2024 оны байдлаар Монгол Улсын 3,441,598 иргэн 997,023 өрхөд бүртгэгдэн амьдарч байгаа бөгөөд нэг өрхөд дунджаар 3.56 хүн ногдож байна. Үүнээс 18 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 61,273 нь нийт өрхийн 6.1 хувь-г, хүүхэдтэй өрхийн 9.7 хувь-г эзэлж байна.

Улсын хэмжээнд 2024 онд 14,225 хос гэрлэлтээ бүртгүүлсэн бол 4,463 хос гэрлэлтээ цуцлуулсан байна. 2023 онд гэрлэлтээ бүртгүүлсэн хосын тоо өмнөх оноос 18.2 хувь-р, гэр бүл цуцлалт 6.5 хувь-р тус тус бууржээ.

Гэр бүлийг дэмжих, зөвлөн туслах хөгжлийн үйлчилгээг 21 аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд Гэр бүлд зөвлөгөө өгөх 5 төв, 29 танхимаар дамжуулан хүргэж, нийт гэр бүлийн үйлчилгээ, гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд, хүмүүжлийн эерэг арга эзэмшүүлэх сургалт, урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээнд 2024 онд нийт гэр бүлийн 41.0 хувь-г хамруулсан. Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг 21 аймаг, нийслэл, дүүргийн харьяа газар, хэлтсүүдээр дамжуулан зохион байгуулж, тогтмолжуулан 2024 онд нийт 271,155 иргэнд гэр бүлийн боловсрол олгосон. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд

зориулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий 764 Хамтарсан багт 6,095 гишүүн 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд ажиллаж байна. 2024 оны байдлаар Хамтарсан багаар гэр бүлийн хүчирхийлэл, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, олон нийт, иргэдийг хүчирхийллийг үл тэвчих хандлага, мэдлэгийг нэмэгдүүлэх 2,201 удаагийн сургалтад 207,365 иргэнийг хамруулж, эрсдэлт нөхцөл дэх 5,444 гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийж, 7,130 кейсийг бүрэн шийдвэрлэсэн.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, насанд хүрэгчдийн аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээг Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр дамжуулан үзүүлдэг бөгөөд улсын хэмжээнд 2025 оны байдлаар 22 түр хамгаалах байр, 17 нэг цэгийн үйлчилгээний төв ажилладаг. Эдгээрээс 17 ТХБ, 9 НЦҮТ нь Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, хэлтсийн харьяа байна.

2024 оны байдлаар 4,882 иргэн үйлчилгээ авснаас 3,073 хүүхэд, 1,809 насанд хүрэгч, үүнээс урт хугацаагаар байрлан үйлчилгээ авсан 537 иргэнээс 479 хүүхэд, 58 насанд хүрэгч байна. Үйлчилгээ авсан хүүхдийн тоо өмнөх оноос 7.1 хувиар буурсан бол насанд хүрэгчдийн тоо 59.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Засгийн газраас 2026 оныг "Хүний хөгжлийг дэмжих жил" болгон зарлаж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхлэх асуудлын хүрээнд "Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо" хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа тул гэр бүлд чиглэсэн сургалт, хөгжлийг дэмжих үйлчилгээг гэр бүлийн хөгжлийн төвөөр дамжуулан хүргэж, гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийг ажлыг эрчимжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Иймд тус хөтөлбөрийн зардлыг батлагдсан төсвийн хязгаараас 373.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын салбарын хэмжээнд ***518.1 сая*** төгрөг төсөвлөлөө.

ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол Улсын төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааны хүрээнд алслагдсан бүс нутаг, сум, дүүрэг, цэцэрлэгийн хүртээмж багатай газруудад хүүхэд харах төвийг нээж, хилийн застав амьдарч байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлснээр ганц бие эх, эцгийн хөдөлмөр, эрхлэлт, асрахуйн эдийн засгийг дэмжих юм.

2025 онд хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан иргэдийн тоо, Боловсролын ерөнхий газраас ирүүлсэн сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтын судалгаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд бөгөөд бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөлийн даргын баталсан "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ"-г хэрэгжүүлэх 2024, 2025 оны төлөвлөгөө, тайлан мэдээлэлд өгсөн саналыг үндэслэн тооцоход тус үйлчилгээнд 2026 онд 2,220 (үүнээс 356 хөгжлийн бэрхшээлтэй) хүүхэд хамруулж 4,834.4 сая төгрөг зарцуулах, цаашид 2027, 2028 онд үйлчилгээнд хамрагдах хүүхдийн тоог өмнөх оноос 30 хувиар нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Гэвч 2026 оны төсвийн хязгаар 2,627.0 болж буурснаас хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх боломжгүй тул өмнөх оноос бууруулан 700 орчим хүүхэд үйлчилгээ авч, ***2,627.0 сая*** төгрөг зарцуулахаар тооцон төсвийн төслийн саналд тусгалаа.

1.2.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар түүний харьяа байгууллагуудын 2026 оны төсвийн төслийг **31,086.5** сая төгрөг, шинээр байгуулагдсан Өмнөговь аймгийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны зардал 1,382.3 сая төгрөгөөр хүргүүлж байна.

Цалин урамшуулалтай холбоотойгоор

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон харьяа нийт 11 байгууллага орон тоог төсвийн хязгаарт батлагдсан 508 орон тооноос 23 орон тоогоор нэмэгдүүлэн нийт 531 орон тоогоор цалин хөлсний тооцоолон төлөвлөлөө. Өмнөговь аймагт шинээр үйл ажиллагаа эхлэхээр Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн зардал орон тоог нэмэгдүүлэн тооцсон.

Үндсэн цалин хөлсний зардалд шинээр байгуулагдаж байгаа Өмнөговь аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн 27 ажиллагсадын цалингаар хязгаараас нэмэгдсэн ба нэмэгдэл цалин хөлсөнд холбогдох хууль тогтоомжийн дагуу аймаг, сумдад ажиллаж байгаа төрийн албан хаагчдөд олгох 20 хувийн нэмэгдэл, хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл, төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл зэргийг тооцож төлөвлөлөө.

Байр ашиглалтттай холбоотой тогтмол зардал:

Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК-ийн 2023 онд мөрдөгдөж байгаа Цахилгаан эрчим хүчний үнэ тариф, 2022 оны 10 дугаар сарын 28-ний өдрөөс Эрчим хүчний зохицуулах хорооны 504, 510 дугаар тоот тогтоолын дагуу "Төсвийн байгууллагад борлуулах цахилгааны тариф энгийн тоолууртай" болж нэмэгдсэн мөн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны хүчин чадлын тариф, Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифууд нэмэгдсэн үнээр тооцож, НӨАТ, мэдээ хүргэлтийн төлбөр, ТВ-ийн хураамж зэргийг тооцож төлөвлөсөн. Энэ нь батлагдсан төсвийн хязгаараас 385.2 сая төгрөгөөр, шинэ барилга ашиглалатад орж шинэ байгууллага нэмэгдсэнтэй холбоотой 199.4 сая төгрөг нийт 584,6 сая төгрөг нэмэгдсэн байна.

Хангамж бараа материалын зардалд нийт 505.9 сая төгрөгөөр төлөвлөсөн ба үүнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдох бичиг хэргийн зардал, шуудан холбооны зардал, ном хэвлэлийн зардал хог хаягдлын зардлыг батлагдсан зарлагын хязгаарт, харин тээвэр шатахуун бага үнэтэй түргэн элэгдэл зүйлийн зардлыг тооцож төлөвлөсөн нь зарлагын хязгаараас 84.5 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Норматив зардал эм, эмнэлэгийн хэрэгсэлийн зардал, хоолны зардал нь үнийн өсөлттэй болон Өмнөговь, Архангай аймгийн хөгжлийн төвүүдийн барилга байгууламж ашиглалтад орж үйл ажиллагаа жигдэрч бүрэн бүтцээр ажиллаж эхэлж байгаатай холбоотойгоор батлагдсан хязгаараас 3.6 сая төгрөгөөр нэмэгдэж төлөвлөгдсөн байна.

Эд хогшил, урсгал засварын зардын зардалд зайлшгүй шаардлагатай Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын урсгал засварт шаардагдах зардлыг тооцоолон төлөвлөсөн ба батлагдсан хязгаараас 34.3 сая төгрөгөөр нэмэгдэж төлөвлөгдлөө.

Томилолтын зардлыг нийт байгууллагуудад үйл ажиллагаатай холбоотой хамрах сум, баг, хороонд бүртгэлтэй байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил хамгаалал, үйлчилгээнд хамруулах, хяналт хийх ажлын шаардлагаар зайлшгүй албан томилолтоор ажиллахад зориулагдах зардлыг тооцож төлөвлөсөн.

Бараа үйлчилгээний бусад зардал

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөрийн харилцаанд оролцох, ажилд зуучлах, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, зөвлөлгөө өгөх чиг үүргийг хэрэгжүүлэхэд сургалт нөлөөллийн ажилд зориулж байгууллага бүрт хичээл үйлдвэрлэлийн зардлыг тооцож төлөвлөлөө.

Бусдаар гүйцэтгүүлэх бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж буюу хөтөлбөрийн зардал, Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн хүрээнд /Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар/:

- Монгол улсад 0-18 насны 14,609 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа 2,700 гаруй хүүхэд байна. Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/64 тушаалаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн үйлчилгээний аргачлал заавар, үнэ тарифыг батлан төрийн бус байгууллагуудыг сонгон шалгаруулж, 2025 онд төсөвт тусгасан 8,9 тэрбум төгрөгөөр хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлж байгаа боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хөгжлийн үйлчилгээг санхүүжүүлэн ажиллаж байна. Тус үйлчилгээ нь хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тохируулгат орчинд өөрт шаардлагатай боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг гэртээ ойрхон, эцэг эхэд санхүүгийн дарамтгүй авснаар хүүхдийн хөгжилд болон гэр бүлд томоохон дэмжлэг бүхий үр дүнтэй үйлчилгээ болсон. Тиймээс 2026 онд байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх дэмжих төвүүдийг аймаг дүүргүүдэд нэмэгдүүлэх зорилтыг тавиад байна. Энэ зардалд нийт **9,579.9 сая** төгрөгийг тооцоолж бусдаар гүйцэтгүүлэх бусад нийтлэг ажил үйлчилгээний зардалд тусгахаар төлөвлөлөө.
- Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 03 дугаарын сарын 27-ны өдрийн А/74 тушаалын дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт Саадгүй байдал, хүртээмжийн газар шинээр бий болж байгаатай холбогдуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний биет орчны үнэлгээ, мэдээллийн хүртээмжийн үнэлгээ, тээврийн хэрэгслийн үнэлгээ, судалгааны ажлуудыг шинээр нэвтрүүлэн ажиллахаар 2026 оны төсвийн саналд **224,0** сая төгрөгийг тусгасан болно.
- Мөн бусад харьяа байгууллагын хувьд **Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр 5,497.7 сая** төгрөг /Төвүүдийн харуул хамгаалалтын зардлыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй уялдуулан гэрээт байгууллагын үнийн дүнд суурилж/ тооцож төлөвлөсөн.

1.2.5. ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд: Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгаалын яамны үйл ажиллагааны зардалд цалин хөлс, НДШ-ийн зардал 960.6 сая төгрөгөөр нэмэгдэхээр тооцоологдсон. Үүнд төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэв нэмэгдэж байгаа, ажилласан жилийн нэмэгдэлийг нэмж тооцоолсон, унаа хоолны мөнгийг нэмэгдүүлэхээр тооцож төлөвлөлөө. Байр ашиглалттай холбоотой зардал 105.6 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 40.0 сая төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардал 62.6 сая төгрөгөөр, томилотын зардлыг 209.1 сая төгрөгөөр батлагдсан төсвийн хязгаараас тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн нь яамны чиг үүргийг ханган ажиллах нөхцөл шаардлагын дагуу холбогдох хууль дүрэм, үйл ажиллагааны төлөвлөгөөнд заагдсан ажил үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардал хүрэлцэхгүй байгаатай холбоотой байна. Нийгмийн даатгалын багц хууль, хувийн нэмэлт тэтгэвэрийн тухай хууль, үндэсний баялгийн сан,

хуримтлалын сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор олон нийтэд сурталчлах таниулах үйл ажиллагаанд 276.0 сая төгрөг тооцоолж төлөвлөлөө.

МУЗГҮАХ-ын төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой: Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн хүрээнд 4,804.5 сая төгрөг төлөвлөсөнөөс Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 2,206.5 сая төгрөг, хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 400.0 сая төгрөг, гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 1,590.0 сая төгрөг, ахмад насны хөгжил хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 881.0 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн нь 2025 оны батлагдсан төсвөөс 2,015.6 сая төгрөгөөр хязгаараас 3,213.7 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний хувь:

- 1.1. МУЗГҮАХ-ын 2.1.1.23, 2.1.1.24 дэх зорилт болон Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 оны хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай (Шинэчилсэн найруулга), Нийгмийн халамжийн тухай (Шинэчилсэн найруулга) Саадгүй байдал, хүртээмжийн тухай (Анхдагч хууль), Дохионы хэлний тухай (Анхдагч хууль) зэрэг хуулиудыг Улсын Их Хуралд өргөн барихаар тусгагдсан. Хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандалт судалгааг боловсруулсан бөгөөд дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төсөл боловсруулах ажлын явц 70 хувьтай байна.
- Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Саадгүй байдал, хүртээмжийн тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандарыг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн "2.1.1.23.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж, нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах эрх зүйн орчныг сайжруулна" гэж тусгагдсан. Энэ хүрээнд олон нийт, хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагчдын ойлголт хандлагыг өөрчлөх, салбарын ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн хүрээнд Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөн туслах улсын үзлэгийг бүх аймаг, дүүргийн 25 ба түүнээс дээш ажиллагчтай аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан зохион байгуулах тухай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/102 дугаар тушаалаар 2025 онд 1000 гаруй аж ахуйн нэгж, байгууллагад улсын үзлэг хийнэ. Цаашид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2026 онд энэ ажлыг үргэлжлүүлэн 600-800 аж ахуйн нэгж, байгууллагад улсын үзлэг хийх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд зөвлөн туслах ажлыг зохион байгуулна.
- Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.1.1.25 - д "Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттайгаар нэвтрүүлж, салбар дундын нийгмийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана." гэж заасан. Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох, тогтоох аргачлалыг олон улсын үйлдлийн чадвар алдалтын системээр /ICF/ тогтоох асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд тусган хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үйлдлийн чадвар алдалтаар нь

үнэлсэнээр нийгмийн халамжийн дэмжлэг тусламжуудыг ялгавартай олгох, туслах хэрэгслийн төрөл хэлбэрийг өргөжүүлэн оновчтой болгох, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр боловсруулж буй бодлогыг оновчтой болгох боломжууд бүрдэх юм. Иймээс тус олон улсын аргачлалыг орчуулах, бодлогын баримт бичгүүдэд оновчтой тусгах, холбогдох олон улсын зөвшөөрөл, лицензийг авах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд нэвтрүүлэн турших ажлыг зохион байгуулна.

Хүүхдийн хөгжил хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа

- Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх, сурталчлах, төрийн бүх байгууллага, аж ахуйн нэгжид хүүхэд хамгааллын бодлого мөрдүүлэх,
- Эцэг эх, хүүхэд, олон нийтэд чиглэсэн урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээг салбар дундын байгууллагатай хамтран зохион байгуулах,
- "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг өргөжүүлж, салбар дундын оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн зөвлөлүүдийг чадавхжуулах
- Хүүхдийн эрх, хамгааллын үзүүлэлт тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж, батлуулах, хүний нөөцийг чадавхжуулах
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын Монгол Улсын Засгийн газрын 6,7 дугаар тайлан боловсруулах

Гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг ажиллуулах, "e-Family" цахим системийг нэвтрүүлэх,тогтворжуулах
- Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих
- Гэр бүл, хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх чиглэлээр Гэр бүл, хүүхдийн шүүхийн байгууллагатай хамтран ажиллах

Ахмад настны хөгжлийг дэмжих хүрээнд

- Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн стандартыг боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангаж 21 аймаг, 360 сум, 204 хороог түшиглэн байгуулах ажлыг зохион байгуулна.

Монгол Улсын Засгийн газраас 2026 онд Хүний хөгжлийг дэмжих чиглэлийг баримталж хэрэгжүүлэх цогц арга хэмжээнд дараах хөтөлбөрүүдэд нийт 17,560.8 сая төгрөг төлөвлөлөө.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН 2026 ОНЫ ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСВИЙН ТӨСЛИЙН НЭГДСЭН ТОВЧОО /сая.төг/

	Хөтөлбөр, зардлын нэр	Хэмжих нэгж	Нийт төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
Шинээр нэмэгдэж байгаа хөтөлбөр, арга хэмжээ				
Урсгал зардал				
5	"Тогтвортой хөгжил ба амьдралын чанар" хөтөлбөр	12,000 оролцогч,	4,200.0	4,200.0
6	"Хүн болох багаасаа-Хүүхдийн хөгжил, оролцоо" хөтөлбөр	56,855 хүүхэд	9,560.8	9,560.8
7	"Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо" хөтөлбөр	21 аймаг, 9 дүүрэг	3,800.0	3,800.0
	Дүн		**17,560.8**	**17,560.8**

1.2.6. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Монгол улсын хэмжээнд "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг судлах, үнэлгээ, дүгнэлт гаргах, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, эрт илрүүлэх, эмчлэх, нөхөн сэргээх, сувилах, хөдөлмөр зохицуулалтын, магадлал хийх, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, сургалтын байгууллагуудын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн удирдамж чиглэл өгөх, хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон сурталчилгааны ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн эмнэлэгийн барилга ашиглалтанд орж үйл ажиллагаа эхэлж байгаатай холбоотой тус төвийн бүтэц орон тоог Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/41 дугаар тушаалаар шинэчлэн 7 газар, 4 нэгжтэй, 179 алба хаагчтай байхаар батласан 2026 төсвийн төсөлд 2026 оны төсвийн хязгаарт батлагдсан 167 орон тоогоор цалин хөлсний зардлыг тооцоолж батлагдсан хязгаарт багтаан төлөвлөлөө.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд Эмнэлэгийн барилга ашилалтанд бүрэн орж эмнэлэгийн үйл ажиллагаа эхэлж байгаатайгаар холбоотойгоор ашиглалтын зардал **106,7** сая төгрөгөөр, Хангамж бараа материалын зардал **9,3** сая төгрөгөөр, норматив зардал /эм бэлдмэлийн зардал, хоолны зардал, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал/ **65.0** сая төгрөгөөр, батлагдсан хязгаараас нэмэгдэн төлөвлөгдсөн.

Аж ахуйн нэгж байгууллагуудад ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг үнэлэх дүгнэлт гаргах ажлын хүрээнд хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ил далд уурхай болон бусад байгууллагуудад газар дээр нь очиж ажиллахад шаардлагатай томилолт, шатахууны зардалд **38,1 сая** төгрөг нэмэгдүүлэн тооцоолж байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж: Эмнэлгийн тоног төхөөрөмж муудаж чанарын шаардлага хангахгүй, зарим тоног төхөөрөмж, аппарат байнгын эвдэрч засвар авахгүй болсонтой холбоотойгоор тоног төхөөрөмж түрээслэх, мөн эмнэлэг болон санхүүгийн программ, сургалтын программын лицанц, багаж баталгаажуулалтын зардлуудын үнэнд өөрчлөлт орсноор нэмэгдсэн, Агаар сувилалын газрын төлбөр, МШӨС-ын эмнэлгийн газрын төлбөрт тус тус татварын өр үүссэн,хэвтэн эмчлүүлэх тасаг нээгдсэнтэй улсын маягт хэвлэх, бэлтгэх, цахим систем шинээр үүсгэх зэрэг үйл ажиллагаанд **113,8 сая** төгрөг батлагдсан хязгаараас нэмж шаардагдахаар тооцоолсон.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 1600,0 сая төгрөгөөр тооцоолж 2025 оны батлагдсан орлогоос **395.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцооллоо.

1.2.7. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ судалгааны институтийг Засгийн газрын "Төсвийн байгууллагыг өөрчлөн зохион байгуулах тухай" 2025 оны 246 дүгээр тогтоолоор "Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт судалгааны хүрээлэн" эрдэм шинжилгээний байгууллага болгон өөрчлөн зохион байгуулсан бөгөөд ГБХНХСайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/126 дугаар тушаалаар дүрэм,зохион байгуулалтын бүтэцийг 67 орон тоотой байхаар баталсан. Иймд 2026 оны төсвийн хязгаарт батлагдсан 68 орон тоог 1 ээр хасаж 67 орон тоогоор 2026 оны цалин хөлсний зардлыг тооцоолсон ба төрийн албн хаагчийн цалингийн шатлал өөрчлөгдөж байгаатайгаар цалин хөлсний зардал батлагдсан хязгаараас **264.9** сая төгрөгөөр нэмэгдэж төлөвлөгдлөө.

Тус хүрээлэн нь 3 тусдаа байранд үйл ажиллагаа явуулдаг нь ажлын гүйцэтгэл техник тоног төхөөрөмжийн нэгдсэн хүртээмж, багаж хэрэгсэл болон туршилт явуулах бусад нөхцөл хангагдахгүй байгаа тул конторын барилга түрээслэх шаардлагатай болсон. Иймд

байрны түрээсийн зардал нэмэгдэж төлөвлөгдсөнөөр байр ашиглалттай холбоотой зардал **129.8 сая** төгрөгөөр батлагдсан хязгаараас нэмэгдэж байна.

Сургалтад хамрагдсан иргэдэд чадамжийн гэрчилгээ олгохтой холбоотой хавтас, үнэт цаас хэвлүүлэх мөн сургалтын завсарлагаанд зориулж цай кофе ус авах шаардлагатай байдаг тул бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд төсөв нэмж төлөвлөсөн.

Байгууллагын интернетийн төлбөрийг Юнивишн ХХК-тай гэрээ хийж өндөр хурдны багцаар 3 газарт интернетийн үйлчилгээ авдаг тул шуудан холбооны зардлыг **19.8** сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөлөө.

Байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орж хөтөлбөрийн үнэлгээ баталгаажуулалтын ажлыг хэрэгжүүлэхгүй болсон төөвт байгууллагын үйл ажиллагаанаас орох орлогыг хасаж төлөвлөлөө. Тус орлого батлагдсан хязгаараар 396,9 сая төгрөг байсныг хасаж тооцсон.

--oOo---

ХОЁР. САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ

Нэг. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа байгууллагуудаас ирүүлсэн санал, хэрэгцээ шаардлагыг үндэслэн 2026 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн саналд 184,739.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 80,289.1 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 30 төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлж байна.

Төсвийн саналд барилга байгууламжийн шинэ болон шилжих 27 төсөл арга хэмжээнд нийт **49,886.0 сая төгрөг,** салбарын хэмжээнд шаардлагатай их засварын төсөл арга хэмжээнд **10,000.0 сая төгрөг**, тоног төхөөрөмжийн саналд **18,400.5 сая төгрөг,** ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл арга хэмжээнд **2,002.5 сая төгрөгийг** тус тус тусгасан болно. Үүнд:

Хүснэгт-1. 2026 оны хөрөнгө оруулалтын төсвийн санал /сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	2026 онд санхүүжих дүн	Барилга байгууламж	Их засвар	Тоног төхөөрөмж	ТЭЗҮ, зураг төсөв
1	Шинэ /11 а.х/	46,358.6	15,955.6	10,000.0	18,400.5	2,000.5
2	Шилжих /19 а.х/	39,930.5	39,930.5	-		-
Нийт		**80,289.1**	**49,886.1**	**10,000.0**	**18,400.5**	**2,000.5**

1.1. БАРИЛГА БАЙГУУЛАМЖ:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт шинээр болох он дамжин баригдаж буй барилга байгууламжид **49,886.1** сая төгрөгийн төсөв шаардлагатай байна.

Үүнээс **2026 онд с**албарын хэмжээнд 39,370.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй **15,955.6** сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 8 барилга байгууламжийг шинээр барих хэрэгцээ шаардлага үүссэн бөгөөд шинэ бүтээн байгуулалтын төсвийг 2-3 жилийн хугацаанд хуваан санхүүжүүлэхээр улсын төсөвт санал хүргүүлж байна. Он дамжин хэрэгжиж буй шилжих 19 төсөл, арга хэмжээнд **33,930.5** сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт-2. Барилга байгууламжийн 2026 оны төсвийн санал /сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Нийт төсөвт өртөг -	2026 онд санхүүжих дүн -	2027 онд санхүүжих дүн -	2028 онд санхүүжих дүн -
		Эхлэх	Дуусах				
1	Шинэ	2026	2028	39,370.9	15,955.6	15,015.4	8,353.0
2	Шилжих	-	2027	114,965.0	39,930.5	8,461.4	-
Нийт				**154,336.9**	**49,886.1**	**23,476.8**	**8,353.0**

1.2.ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын байгууллагуудаас ирүүлсэн шаардлагатай тоног төхөөрөмжийн саналыг нэгтгэн нийт 18,400.5 сая төгрөгийг саналын нэгтгэн төсөвлөсөн.

Хүснэгт-3. Тоног төхөөрөмжийн 2026 оны төсвийн санал /сая.төг/

№	Тоног төхөөрөмж	Санхүүжих дүн
	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	18,400.5
1	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын харьяа байгууллагуудын автотээврийн хэрэгсэл /Улсын хэмжээнд/-Тоёота-150	2,470.0
2	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын харьяа байгууллагуудын автотээврийн хэрэгсэл /Улсын хэмжээнд/-Хьюндай-Старекс	650.0
3	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын харьяа байгууллагуудын албан хэрэгцээнд суурин компьютер /Улсын хэмжээнд/	1,060.8
4	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын харьяа байгууллагуудын албан хэрэгцээнд зөөврийн компьютер /Улсын хэмжээнд/	427.7
5	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын харьяа байгууллагуудын албан хэрэгцээнд олон үйлдэлт принтер /Улсын хэмжээнд/	1,035.3
6	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын харьяа байгууллагуудын албан хэрэгцээнд хурдан скайнер /Улсын хэмжээнд/	287.0
7	Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд суурин компьютер /Улсын хэмжээнд/	4,708.0
8	Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд зөөврийн компьютер /Улсын хэмжээнд/	1,680.0
9	Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа байгууллагуудын албан хэрэгцээнд олон үйлдэлт принтер /Улсын хэмжээнд/	450.0
10	Нийгмийн даатгалын ерөнхий газрын МТТ-ийн Сервер компьюьтер	700.0
11	Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа байгууллагуудын сүлжээний төхөөрөмжүүд /Улсын хэмжээнд/	276.0
12	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаллын ерөнхий газрын байгууллагуудын албан хэрэгцээнд суурин компьютер /Улсын хэмжээнд/	1,402.1
13	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаллын ерөнхий газрын байгууллагуудын албан хэрэгцээнд - Хьюндай стариа автомашин	1,820.0
14	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаллын ерөнхий газрын байгууллагуудын албан хэрэгцээнд Хьюндай Соната ДН8 автомашин	118.0
15	Сэлэнгэ аймгийн ХГБХХГазрын тоног төхөөрөмж	515.6
16	Баян-өлгий аймгийн ХГБХХГазрын тоног төхөөрөмж	400.0
17	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эмчилгээний тусгай зориулалтын автомашин	400.0

Улсын хэмжээнд нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагаа цахимжиж байгаатай холбоотой шинэ сервер худалдаж авах, тус серверийн техникийн нөхцөлд тохирсон шаардлагатай компьютер, тоног төхөөрөмжийн хэрэгцээ тулгараад байна.

Одоогоор орон нутгийн байгууллагад ашиглагдаж байгаа 30 сервер компьютер болон сургалтын дэлгэц, проектор зэрэг зарим дагалдах техник хангамжийн ашиглалтын хугацаа дууссан байна. Цахим шилжилтийн хүрээнд ажилтан тус бүрд олон үйлдэлт принтер шаардлагатай байна. Учир нь иргэдийн анхан шатны цаасан баримтыг тус бүрчлэн цахим системд байршуулдаг болсонтой холбогдуулан улсын хэмжээнд 4,474.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв нь Олон улсын стандартад нийцсэн орчин үеийн төрөлжсөн нарийн мэргэжлийн 8 давхар 47 ортой шинэ эмнэлэг 2025 оны 2 дугаар улиралд ашиглалтад орж багаж тоног төхөөрөмж нэмэгдсэнээр явуулын болон суурин хэлбэрээр эрүүл мэндийн үзлэгийг 2 дахин нэмэгдүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

Түүнчлэн Монгол улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 45 дугаар хурлын тэмдэглэлийн 1 дүгээр зүйлд Мэргэжлийн өвчин судлалын эмнэлгийг 2024 оны 2 дугаар улиралд ашиглалтад оруулахаар тусгасан. Мэргэжлийн өвчин судлалын эмнэлэг ашиглалтад орсноор улсын хэмжээнд хөдөлмөрийн хүнд, хортой, халуун газрын гүнд ажиллаж байгаа болон нийт аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтнуудад эмнэлгийн

тусламж үйлчилгээг цогцоор нь хүргэх, үзлэг оношилгоо хийх таатай орчин нөхцөл бүрдэх, хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтнуудын эрх ашиг, эрүүл мэндийг нь хамгаалах амьдралын чанарыг нь дээшлүүлэх, мэргэжлийн өвчний хяналт сайжирч, ердийн өвчний хүндрэл, гэнэтийн үхэл, нас баралтын хэмжээг бууруулахаар зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Тус эмнэлэг ашиглалтад орж байгаатай холбоотой эмнэлгийн болон лабораторийн тоног төхөөрөмж шинээр худалдан авахад 4,221.6 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын ерөнхий газрын албан хаагчдад болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв шинээр байгуулагдсантай холбоотой ажилтан албан хаагчдад зориулсан тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлага үүссэн ба 2026 оны төсвийн саналд 1,303.5 сая төгрөг зэрэг саналуудыг салбарын хэмжээнд нэгтгэн хүргүүлж байна.

1.3. ИХ ЗАСВАР:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын байгууллагуудаас ирүүлсэн барилга байгууламжийн их засварын саналыг нэгтгэн барилга байгууламжийг засах засварын ажлын санхүүжилтэд 10,000.0 сая төгрөгийг төлөвлөсөн.

Хүснэгт 4. Их засварийн төсвийн санал/сая.төг/

№	Их засвар	Санхүүжих дүн
	Гэр бүл, ходолмөр, нийгмийн хамгааллын салбарын их засвар /Улсын хэмжээнд/	**10,000.0**
1	ОУХНЦ-Өвлийн хоолны газрын их засвар	1,266.0
2	ОУХНЦ- Задгай театр, хөл бөмбөгийн талбайн их засвар	1,488.9
3	ОУХНЦ-Хараацай театрын дотор засвар	1,079.6
4	ОУХНЦ-Зуны хотхоны засвар /Одод, Оч, Сансар бүлэг/	214.9
5	Төв аймгийн НДХ-ийн барилгын их засвар	940.7
6	Сүхбаатар аймгийн гэр бүл,хүүхэд,залуучуудын хөгжлийн газарын гэр бүл, хүүхэд, залуучуудыг хөгжлийн газарын их засвар	734.5
7	Өнөр бүл хүүхдийн төвийн Өвлийн байрын их засвар	191.0
8	Говь-алтай аймгийн ХГБХХГазрын Андууд зуслангийн их засвар	1,187.3
9	Дархан-Уул аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарын Хүүхдийн ордоны их засвар	131.1
10	Салбарын бусад барилгын их засвар	866.0
11	Ахмадын сувилалын барилгын их засвар Сүхбаатар дүүрэг	1,300.0
12	Завхан аймгийн Мичид кино театрын их засвар	600.0

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын албан конторын дээвэр, цахилгаан, цэвэр бохир усны шугам зэргийг шинэчлэн засварлах шаардлагатай байна. Учир нь гэрэл, ламп сольсон хэдий ч шууд масс өгч, шатдаг, гэрэлтүүлэг маш муу байдаг. Иймд шөнө оройгоор албан хаагчид ажиллах нөхцөл хүнд байдаг. Мөн албан конторын барилгын В1 давхарт архивын 2 өрөө, агуулахын 3 өрөө, граш байрладаг. 2013 онд ашиглалтад орсон хугацаанаас засвар огт хийгдээгүй. Дээврийн ус хана дагаж нэвтэрдгээс үүдэг хана, шал, таазны өнгө үзэмж муудсан, тоосонцор, шороо их нэвтэрдэг нь архивын баримт хадгалалт хамгаалалтад эрсдэл учруулдаг, конторын барилгын цэвэр, бохир ус халаалтын шугам муудсанаас ус, дулаан их алддаг тул зайлшгүй засаж сайжруулах шаардлагатай байна.

➢ Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолбор: Цогцолбор нь ашиглалтад орсноос хойш тасралтгүй 44 жил үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд барилга, объект, үндсэн хөрөнгүүдийн биет байдал муудаж, үзэмж буурсан тул засварыг хэсэгчлэн болон зарим объектод бүрэн хийх шаардлагатай байна. Цогцолборын засварыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд одоогийн байдлаар Төв байрны их засвар, дулааны цехийн шинэчлэл, гадна шугам хоолойн засварыг хийж гүйцэтгэсэн байна.

➢ Өнөр бүл хүүхдийн төв: Цэцэрлэгийн барилга нь ашиглалтад орсноос хойш тасралтгүй 40 жил үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд барилга, объект, үндсэн хөрөнгүүдийн биет байдал муудаж, үзэмж буурсан тул засварыг хэсэгчлэн болон зарим объектод бүрэн хийх шаардлагатай байна. Цэцэрлэгтйн барилгыг 2024 онд дотор засал, засвар хийсэн хэдий дээвэр засвар хийгээгүйгээс шалтгаалан өмнөх засварыг үр дүнгүй болгох эрсдэл үүсээд байна. Иймд 187.5 сая төгрөгөөр дээврийн засвар хийх саналыг 2026 оны төсвийн саналд хүргүүлж байна.

1.4. ТЭЗҮ:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах шаардлагатай байгаа төсөл, арга хэмжээг нэгтгэн 2,000.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 5. ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсвийн санал/сая.төг/

№	ТЭЗҮ	Санхүүжих дүн
	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах /Улсын хэмжээнд/	**2,000.5**
1	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын байрны зураг төсөв	68.8
2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын конторын засварын зураг төсөв /Төв аймаг/	25.0
3	Ахмадын амралтын газрын барилгын их засварын ажлын зураг төсөв /Төв аймаг/	31.2
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв-Сэргээн засах төв байгуулах төсөл	275.0
5	Нийгмийн даатгалын газрын конторын барилгын зураг, төсөв /Архангай, Эрдэнэбулган, 3-р баг/	93.8
6	Нийгмийн даатгалын газрын конторын барилгын зураг, төсөв /Дорноговь, Сайншанд, 6-р баг/	93.8
7	Нийгмийн даатгалын газрын барилгын их засварын зураг, төсөв /Завхан, Улиастай, 1-р баг/	31.3
8	Нийгмийн даатгалын салбарын архивын барилгын зураг, төсөв /Төв, Зуунмод, 1-р баг/	168.8
9	Нийгмийн даатгалын газрын барилгын их засварын зураг, төсөв /Увс, Улаангом, 11-р баг/	18.8
10	Нийгмийн даатгалын газрын барилгын их засварын зураг, төсөв /Говьсүмбэр, Сүмбэр, 2-р баг/	12.5
11	Нийгмийн даатгалын хэлтсийн өргөтгөл барилгын зураг, төсөв /Улаанбаатар, Хан-Уул, 19-р хороо/	162.5
12	Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс хуучин барилга нураах /Улаанбаатар, Сонгинохайрхан/	21.3
13	Хүүхдийн шинжлэх ухааны төв байгуулах зураг төсөл	200.0
14	Салбарын бусад ТЭЗҮ	800.0

---oOo---

ГУРАВ. ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН 2026 ОНЫ ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газраас 2026 онд Хүний хөгжлийг дэмжих чиглэлийг баримталж, цогц арга хэмжээнүүд хэрэгжүүлэх гэж байгаатай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар доорхи арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН 2026 ОНЫ ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСВИЙН ТӨСЛИЙН НЭГДСЭН ТОВЧОО */сая.төг/*

	Хөтөлбөр, зардлын нэр	Хэмжих нэгж	Нийт төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	Эх үүсвэр
Шинээр нэмэгдэж байгаа хөтөлбөр, арга хэмжээ					
Урсгал зардал					
1	"Тогтвортой хөгжил ба амьдралын чанар" хөтөлбөр	12,000 оролцогч,	4,200.0	4,200.0	Улсын төсөв
2	"Хүн болох багаасаа-Хүүхдийн хөгжил, оролцоо" хөтөлбөр	56,855 хүүхэд	9,560.8	9,560.8	Улсын төсөв
3	"Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо" хөтөлбөр	21 аймаг, 9 дүүрэг	3,800.0	3,800.0	Улсын төсөв
	Дүн		**17,560.8**	**17,560.8**	
Хөрөнгө оруулалт					
4	Барилга байгууламж	8	39,371.0	15,955.6	Улсын төсөв
5	Их засвар	12	10,000.0	10,000.0	Улсын төсөв
6	Тоног төхөөрөмж	18	18,400.5	18,400.5	Улсын төсөв
7	ТЭЗҮ	12	2,002.5	2,002.5	Улсын төсөв
	Дүн		**69,774.0**	**46,358.6**	
	Нийт дүн		**87,334.8**	**63,919.4**	

Хүний хөгжлийг дэмжих чиглэлийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

ХӨТӨЛБӨР 1."ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА АМЬДРАЛЫН ЧАНАР"

Зорилго: Эрүүл мэнд, санхүү, сэтгэлзүйн боловсрол, ногоон хөгжил, тогтвортой, хэмнэлттэй аж амьдралын талаарх мэдлэгийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах.

Арга хэмжээ	Тайлбар	Хүрээ	Төсөв (сая ₮)
1."Амьдралын ухаан" иргэдийн боловсролын багц сургалт	Санхүү, эрүүл мэнд, сэтгэлзүй, хүүхэд хүмүүжил	12,000 хүн	1,200.0
2."Ногоон амьдрал – тогтвортой хөгжил" кампанит ажил	Эко дадал, ухаалаг хэрэглээ, хог хаягдлын боловсрол	21 аймаг, 9 дүүрэг	3,000.0
Дүн			4,200.0

Хөтөлборийн хүлээгдэж буй үр дүн

Үр дүн	Тайлбар
1. 12,000 иргэн амьдралын чадавхаа нэмэгдүүлнэ	Санхүүгийн хариуцлага, эрүүл мэндийн мэдлэг, стресс зохицуулах чадвар, хүүхэд хүмүүжлийн зөв арга барил эзэмшинэ

2. Ногоон хэрэглээ, байгаль хамгааллын мэдлэг нэмэгдэнэ	21 аймаг, 9 дүүргийн олон нийтийг хамарсан мэдээлэл, дадал хэвшүүлэх кампанит ажлаар байгальд ээлтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ
3. Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын талаарх ойлголт гүнзгийрнэ	Бүх түвшний төлөөллийг хамруулсан чуулганаар бодлого боловсруулагч, иргэдийн ойлголцол, хамтын оролцоо нэмэгдэнэ
4. Иргэдийн амьдралын чанар дээшилнэ	Сэтгэлзүй, эрүүл мэнд, орчны тэнцвэрт байдлыг дэмжсэн амьдралын хэв маягт шилжинэ
5. ИНБ болон олон нийтийн оролцоо нэмэгдэнэ	Тогтвортой хөгжил, амьдралын чанарын асуудалд иргэний нийгмийн идэвх, оролцоо чухалчлагдана

Хэрэгжүүлэх байгууллага: ба үүрэг оролцоо

Байгууллага	**Үүрэг, оролцоо**
ГБХНХЯ (удирдагч байгууллага)	Бодлогын уялдаа, төлөвлөлт, төсвийн хуваарилалт, хяналт үнэлгээ
Эрүүл мэндийн яам	Эрүүл мэндийн боловсрол, сэтгэлзүйн үйлчилгээний агуулга боловсруулах, сургагч багш бэлтгэх
Сангийн яам, Боловсролын байгууллагууд	Санхүүгийн боловсролын сургалт, хэрэглээний мэдлэг олгох контент боловсруулах
БОАЖЯ	Ногоон хөгжил, эко хэрэглээний бодлогын дэмжлэг, агуулгын боловсруулалт
Орон нутгийн ЗДТГ, Нутгийн хөгжлийн сангууд	Кампанит ажлыг зохион байгуулах, иргэдийг татан оролцуулах
ТББ, Иргэний нийгмийн байгууллагууд	Сургалт, чуулган, эко кампанит ажлын хэрэгжилтэд оролцох, мэдээллийн сувгийг ашиглан хүрэлцээ нэмэгдүүлэх
НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр (UNDP), Уур амьсгалын сан зэрэг олон улсын байгууллагууд	Хамтран хэрэгжүүлэх боломжит санхүүжилт, арга зүйн дэмжлэг үзүүлэх

Энэхүү хөтөлбөрөөр **ОНХС, олон улсын донорын хамтын ажиллагаа**, хувийн хэвшлийн **нийгмийн хариуцлагын төсөлтэй** уялдуулснаар санхүүгийн ачааллыг хуваах, тогтвортой байдлыг хангах боломжтой.

ХӨТӨЛБӨР 2. "ХҮН БОЛОХ БАГААСАА-ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ОРОЛЦОО", "ЧАНАРТАЙ АМЬДРАЛ-ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН ОРОЛЦОО" ХӨТӨЛБӨР

Төсөвт өгөх санал:

Хөтөлбөр	**Төсөв (сая.төг)**
1. Хүн болох багаасаа-Хүүхдийн хөгжил, оролцоо	9,560.8
Нийт дүн	9,560.8

Нийт хүлээгдэж буй үр дүн:

- Гэр бүлийн хүчирхийлэл буурч, эерэг харилцаа төлөвшинө
- Иргэдийн амьдралын чанар, сэтгэлзүйн дархлаа, боловсрол дээшилнэ
- Гэр бүл салалтыг тодорхой түвшинд бууруулна
- Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжсэнээр хүүхдийн өөртөө итгэх итгэл нэмэгдэнэ
- Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжсэнээр нийгмийн идэвхтэй иргэн болон төлөвшинө
- Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилт, амьдралын чанарт дэмжлэг үзүүлнэ

1. "Хүн болох багаасаа-Хүүхдийн хөгжил, оролцоо"

Зорилго: Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжсэнээр зорилтот бүлгийн, ялангуяа алслагдсан орон нутагт амьдарч байгаа болон асрамж халамжийн төвд амьдарч байгаа, чадварын ялгаатай тусгай хэрэгцээт хүүхдийн нас, танин мэдэхүйн хөгжлийн онцлогт тохирсон

байдлаар бүх хүүхдийг орхигдуулахгүй жигд хөгжүүлдэг байхад анхаарч, ялгаварлан гадуурхалт болон аль нэг бүлэгт давуу байдал үүсгэхгүй тэгш байдлыг бүрдүүлнэ.

Арга хэмжээ	Хэлбэр	Тайлбар	Хүрээ	Төсөв (сая.төг)
1.Хөгжлийг дэмжих үйлчилгээ	• Бие махбодын • Танин мэдэхүйн • Нийгэмшихүйн	Нийт зорилтот бүлгийн хүүхдийн 35 хувь	23,625	6,127.8
2.Оролцоог дэмжих үйлчилгээ	• Чуулга, уулзалт • Зусланд хамруулах • Хүүхэд гишүүнчлэлтэй зөвлөл, клуб, холбоодын санал санаачилга		33,230	3,433.0
	Дүн			**9,560.8**

Хүлээгдэж буй үр дүн:

Улсын хэмжээнд жилд дунджаар 47 хүүхдийн зусланд 86,0 мянга орчим хүүхэд, 15 хүүхдийн хөгжлийн ордон, 4 хүүхдийн театр, 6 аймагт хөгжлийн төвд зохион байгуулагддаг 70-89 төрлийн секц, хөгжүүлэх сургалт, дугуйланд 150,0 мянга гаруй хүүхэд хөгжлийн үйлчилгээнд хамрагдаж байна.

Зорилтот бүлгийн 160,0 мянга гаруй хүүхэд аливаа хүүхэд хөгжлийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгааг тэгш хамруулах боломж бүрдэнэ.

2. "Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо"

Зорилго: Гэр бүлийн боловсрол олгох хөтөлбөрийг боловсронгуй болгон гэр бүлд чиглэсэн сургалт, хөгжлийг дэмжих үйлчилгээг гэр бүлийн хөгжлийн төв болон efamily цахим платформоор дамжуулан хүргэж, сургалт нөлөөллийн үйл ажиллагааг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэлээр хамтран хэрэгжүүлж гэр бүлийн гишүүдийн хоорондын эерэг харилцааг төлөвшүүлж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг өрх бүрд төлөвшүүлж, гэр бүл салалтыг бууруулахад эерэг нөлөө үзүүлэх зорилготой.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

Арга хэмжээ	Хамрах хүрээ	Төсөв (сая.төг)
1.Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг байгуулж, ажиллуулах	7 төв	800.0
2.Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийг ажлыг хэрэгжүүлэх	21 аймаг, 9 дүүрэг	500.0
3."Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо" хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх	Улсын хэмжээнд	1,000.0
4.Гэр бүлийн "e-Family" цахим системийн үйл ажиллагааг нэвтрүүлэх	Улсын хэмжээнд	500.0
5.Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх	Улсын хэмжээнд	500.0
6.Гэр бүл, хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх чиглэлээр шүүхийн байгууллагатай хамтран ажиллах	Улсын хэмжээнд	500.0
Дүн		**3,800.0**

Хүлээгдэж буй үр дүн:

1. Гэр бүлийн боловсрол дээшилнэ
2. Гэр бүлийн хүчирхийлэл буурна
3. Гэр бүл салалтыг буурна
4. Хүүхэд аюулгүй, тогтвортой гэр бүлд өснө
5. Гэр бүлийн гишүүдийн сэтгэл зүй, эрүүл мэнд хамгаалагдана

---o0o---

МАЯГТ ТМ-01, ТӨСВИЙН САНАЛ

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН САНАЛ

А. ЗАРДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗҮЙЛС

/мян.төг/

Код	Эдийн засгийн ангилал	Хөтөлбөрийн код									
		ГҮЙЦЭТГЭЛ			САНАЛ				ТӨСӨӨЛӨЛ		ӨӨРЧЛӨЛТ	
		2024 Гүйц	2025 Батлагдсан	2025 ХБГ	2026 Хяз	2026 ТЕЗ санал	2026 ТЕЗ Шинэ ХО урсгал	2026 ТЕЗ Хүн амын есөлт	2027 төсөөлөл	2028 төсөөлөл	2026 хяз 2026 сан	2026 хяз 2026 сан
1	2	3.0	4.0	5.0	6.0	7.0	8.0	9.0	10.0	11.0	14	17
58	**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫ**	**3,862,273,288.1**	**4,536,689,933.9**	**4,502,575,385.6**	**4,456,592,695.4**	**4,450,036,145.8**	**7,709,819.4**	**1,004,944,814.4**	**6,150,484,109.7**	**6,688,672,060.6**	**-0.1%**	**(6,556,549.6)**
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗӨЭЛИЙН ДҮН	3,862,273,288.1	4,536,689,933.9	4,502,575,385.6	4,456,592,695.4	4,450,036,145.8	7,709,819.4	1,004,944,814.4	6,150,484,109.7	6,688,672,060.6	-0.1%	(6,556,549.6)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,817,260,655.5	4,443,461,910.1	4,412,861,561.8	4,388,506,041.0	4,392,515,316.0	7,709,819.4	1,004,944,814.4	6,093,563,740.5	6,639,790,761.4	0.1%	4,009,275.0
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	216,704,322.2	331,975,906.5	310,460,213.5	283,186,417.3	282,818,297.0	7,709,819.4	45,473,204.2	413,406,636.3	438,599,422.1	-0.1%	(368,120.3)
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	142,745,175.1	187,545,390.5	195,495,752.4	182,675,962.8	187,486,983.0	4,165,014.2	12,717,449.4	245,570,996.7	257,803,585.1	2.6%	4,811,020.2
210101	Үндсэн цалин	76,091,403.9	90,475,832.1	96,515,835.6	90,384,906.2	83,882,734.1	1,795,632.0	11,945,196.0	111,244,791.0	116,533,168.8	-7.2%	(6,502,172.1)
210102	Нэмэгдэл	39,071,204.7	56,846,891.7	53,908,842.1	50,020,884.5	56,196,950.5	1,304,906.2	-	71,385,878.9	75,822,409.4	12.3%	6,176,066.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,735,452.3	21,861,827.5	25,075,559.4	23,501,800.2	27,372,238.7	765,204.0	-	37,879,361.2	39,410,372.8	16.5%	3,870,438.5
210104	Урамшуулал	12,779,275.6	18,360,839.2	19,995,515.3	18,768,371.9	20,035,059.7	299,272.0	465,137.4	25,060,965.6	26,037,634.1	6.7%	1,266,687.8
210105	Гэрээт ажлын цалин	67,838.6	-	-	-	-	-	307,116.0	-	-		-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ши	17,494,642.3	23,814,357.3	24,410,651.0	22,826,155.0	23,417,117.0	520,626.7	1,589,681.4	30,653,054.6	32,172,032.7	2.6%	590,962.0
210201	Тэтгэврийн даатгал	12,051,233.7	16,193,614.0	16,599,664.1	15,500,798.7	15,923,639.5	354,026.3	1,080,983.3	20,844,078.1	21,876,983.8	2.7%	422,840.8
210202	Тэтгэмжийн даатгал	1,407,124.7	1,904,675.6	1,952,922.9	1,835,761.2	1,873,369.4	41,650.0	127,174.6	2,452,244.5	2,573,762.1	2.0%	37,608.2
210203	ҮОМШ-ний даатгал	715,876.0	988,338.2	976,494.3	916,109.1	936,684.8	20,825.0	63,587.3	1,226,122.1	1,286,881.2	2.2%	20,575.7
210204	Ажилгүйдлийн даатгал	644,317.2	918,378.4	976,292.0	914,698.8	936,684.2	20,825.0	63,587.3	1,226,121.5	1,286,880.6	2.4%	21,985.4
210205	Эрүүл мэндийн даатгал	2,676,090.7	3,809,351.1	3,905,277.7	3,658,787.2	3,746,739.1	83,300.4	254,348.9	4,904,488.4	5,147,525.0	2.4%	87,951.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,376,342.0	15,240,037.6	14,160,561.1	12,168,862.8	15,240,254.3	1,462,005.4	-	19,239,045.1	21,353,931.7	25.2%	3,071,391.5
210301	Гэрэл, цахилгаан	1,800,079.0	3,991,149.8	3,425,878.5	3,291,875.5	3,478,432.4	236,220.2	-	4,326,190.2	5,272,185.4	5.7%	186,556.9
210302	Түлш, халаалт	5,413,048.9	8,428,198.4	7,934,481.2	6,184,308.7	8,765,198.4	1,118,287.0	-	11,368,637.0	12,351,512.4	41.7%	2,580,889.7
210303	Цэвэр, бохир ус	868,946.1	1,526,398.7	1,568,888.8	1,404,267.5	1,666,665.8	107,498.2	-	1,994,589.7	2,178,223.1	18.7%	262,398.3
210304	Байрны түрээс	1,294,268.0	1,294,290.7	1,231,312.6	1,288,411.1	1,329,957.7	-	-	1,549,628.2	1,552,010.8	3.2%	41,546.6
2104	Хангамж, бараа материалын зардал	3,238,181.0	3,285,201.0	5,143,948.5	4,125,538.1	6,497,263.3	314,781.9	-	8,440,254.5	9,080,395.1	57.5%	2,371,725.2
210401	Бичиг хэрэг	963,183.9	654,561.3	1,221,782.8	1,132,196.3	1,555,386.4	12,095.5	-	2,103,969.5	2,266,768.4	37.4%	423,190.1
210402	Тээвэр, шатахуун	614,786.9	595,083.3	1,222,721.4	625,922.2	1,825,035.9	203,069.0	-	2,596,632.8	2,808,295.1	191.6%	1,199,113.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	440,559.1	675,416.0	809,374.8	779,508.4	1,238,704.8	19,926.7	-	1,176,316.7	1,271,797.0	58.9%	459,196.4
210404	Ном, хэвлэл	23,573.3	72,248.3	292,688.8	236,083.5	265,174.5	-	-	242,831.6	271,650.0	12.3%	29,091.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдий	129,851.9	287,924.8	292,349.2	284,386.2	334,121.8	14,380.0	-	462,200.5	496,015.9	17.5%	49,735.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүй	1,066,225.9	999,967.3	1,305,031.5	1,067,441.5	1,278,839.9	65,310.7	-	1,858,303.4	1,965,868.7	19.8%	211,398.4
2105	Норматив зардал	7,917,180.3	8,751,331.4	11,168,583.6	11,977,204.0	12,719,099.0	890,999.4	-	15,440,946.1	16,661,835.4	6.2%	741,895.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,355,124.4	1,810,513.3	1,972,823.7	1,960,421.6	2,221,499.5	51,250.0	-	2,987,723.2	3,306,950.1	13.3%	261,077.9
210502	Хоол, хүнс	5,483,447.8	5,760,959.8	7,299,768.5	8,105,569.7	7,938,371.9	787,814.4	-	9,692,383.9	10,307,745.6	-2.1%	(167,197.8)
Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь "8.2.1. Хуримтлалын сангийн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх ..." гэж заасны дагуу Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан болох Хуримтлалын сангийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсөөллийг Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Засгийн газрын 2024 оны 224[1] дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журам", Засгийн газрын 2025 оны 72[2] дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагын бодлого", Засгийн газрын 2025 оны "Хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" 228[3] дугаар тогтоол, Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Монголбанк хооронд байгуулсан 98,А/132,2025/195,0525/183 дугаартай "Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах ерөнхий гэрээ", Хуримтлалын сангийн 2024 оны жилийн эцсийн болон 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, Эрдэнэс Монгол ХК-аас ирүүлсэн саналд үндэслэн тус тус боловсрууллаа.

Хуримтлалын сангийн гүйцэтгэл

Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын санд уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгаас 499.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан бөгөөд 2024 оны гүйцэтгэлээр Хуримтлалын сангийн Монголбанкан дахь төрийн сангийн дансанд 495.6 тэрбум төгрөг төвлөрсөн.

Монголбанкнаас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Хуримтлалын ... сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанкан дахь төрийн сангийн дансанд байршуулна. Монголбанк Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд бодлогын хүүгээс багагүй хувиар хүү тооцох, эсхүл бодлогын хүүгээс багагүй өгөөжтэй, санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулна." гэж заасан бөгөөд уг хуулийн заалтын дагуу сангийн хүүгийн орлогын 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцон үзэхэд 46.4 тэрбум төгрөг болохоор байсан. Харин холбогдох хууль, Засгийн газрын 179 дүгээр тогтоолын 3 дахь заалт Сангийн яам, Монголбанк хооронд байгуулсан 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 81-0524/171 дүгээртэй "Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах гэрээ"-ний 2.3, 2.6-д заасны дагуу Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанкан дахь дансанд байрших хугацаанд бодлогын хүүгээр, хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө оруулснаас хойш хөрөнгө оруулалтын хүүгээр тус тус тооцно гэж заасан бөгөөд 2024 онд 4.9 тэрбум төгрөгийн хүүгийн орлого төвлөрсөн.

---

[1] https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355676272241

[2] https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355959684341

[3] https://legalinfo.mn/mn/detail?lawId=17431389332742

Түүнчлэн Хуримтлалын санд 2024 онд төвлөрсөн мөнгөн хөрөнгөөс 480.2 тэрбум төгрөгийг арилжааны Ариг, Богд, Голомт, Капитрон, Хаан, Төрийн, Худалдаа Хөгжлийн, М зэрэг 9 банкаар дамжуулан орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн эх үүсвэрт хөрөнгө оруулан ажилласан. Дээрх сангийн мөнгөн хөрөнгийн эх үүсвэрээр 2024 онд 4158 иргэн (нийслэлд 2149, орон нутагт 2009 иргэн) ипотекийн зээлд хамрагдсан байна.

Хуримтлалын сангийн 2025 оны батлагдсан төлөвлөгөө хүлээгдэж буй гүйцэтгэл:

Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар Уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгаас 507.1 тэрбум төгрөг, хүүгийн орлогоор 55.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр, Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562.1 тэрбум төгрөг байхаар тус тус хуульчилсан.

Энэхүү эх үүсвэрийг төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрийг санхүүжүүлэх замаар санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулж, арвижуулах, Монголбанктай гэрээ байгуулах эрх олгох агуулга бүхий Засгийн газрын тогтоолын төслийг 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн.

Хуримтлалын санд 2025 оны “Мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах ерөнхий гэрээ”-г 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын Засгийн газар Монголбанк хооронд байгуулсан.

“Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн хөтөлбөр”-т хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд банкуудад олгосон санхүүжилтийн хүүгээр хүү тооцогдох бөгөөд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.3-т заасан хүүгийн өгөөж хооронд зөрүүг Улсын төсөвт тусгаж батлуулахаар зохицуулсан.

2025 оны 06 дугаар сарын байдлаар санд 103.3 тэрбум төгрөгийн ногдол ашиг төвлөрсөн бөгөөд хүлээгдэж буй гүйцэтгэлээр сангийн орлого 507.1 тэрбум төгрөг, 2024 оны хүүгийн зөрүүний орлого 37.6 тэрбум төгрөг, 2025 оны хүүгийн орлогоос 8.4 тэрбум төгрөг тус тус төвлөрч сангийн 2025 оны орлого 553.8 тэрбум төгрөг, нийт хөрөнгө 1.1 их наяд төгрөгт хүрэхээр байна. Мөн 2025 онд сангийн хөрөнгөөс 562.1 тэрбум төгрөгийг Засгийн газрын 2025 оны 228 тогтоолоор төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөтөлбөрт хөрөнгө оруулахаар байна.

Хуримтлалын сангийн 2026 оны төсөв, 2027-2028 оны төсвийн төсөөлөл:

Хуримтлалын санд төвлөрүүлэх орлогын төсөөллийг Эрдэнэс Монгол ХК-аас ирүүлсэн саналыг үндэслэн хуримтлалын сангийн орлогыг 2026 онд 372.9 тэрбум төгрөгөөр, 2027 оны орлогын төсөөллийг 391.5 тэрбум төгрөгөөр, 2028 оны орлогын төсөөллийг 411.1 тэрбум төгрөгөөр тус тус тооцлоо.

Харин сангийн хөрөнгийн хүүгийн орлогыг Монголбанкны бодлогын хүү 12 хувиар тооцсон бөгөөд 2026 оны хүүгийн орлого нийт 203.6 тэрбум төгрөг (2025 оны хүүгийн зөрүүний үлдэгдэл 57.8 тэрбум төгрөг, 2026 оны хүүгийн зөрүү болох 121.6 тэрбум төгрөг, 2026 оны хөрөнгө оруулалтын хүүгийн орлогыг 24.3 тэрбум төгрөг), 2027 оны хүүгийн орлогын төсөөллийг 207.3 тэрбум төгрөг, 2028 оны хүүгийн орлогын төсөөллийг 277.9 тэрбум төгрөгөөр тус тус төсөвлөв.

Мөн Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 2026 онд 452.3 тэрбум төгрөг, 2027 онд 537.4 тэрбум төгрөг, 2028 онд 618.5 тэрбум төгрөг байхаар төсөвлөв.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ 2026 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСВИЙН САНАЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын"-ын 3.1-д "Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ" гэж заасан зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-ийн 2-т "Тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлсэн байна" гэж, 2 дугаар хавсралтаар батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 3.1.4-т "Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ" гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 3.1.1-д "нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээр тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ" гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлгдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.3.4-т "Хагас хуримтлалын тогтолцоонд шилжиж, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах хууль эрх зүйн зохицуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ" гэж, 2.1.3.5-д "Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ", 2.1.3.6-д "Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулах" гэж заасан.

Дээрх бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус яамнаас Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, намрын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Иймд дээрх хуулийн төслүүдийг иргэд, олон нийт, даатгуулагч, ажил олгогч нарт танилцуулж, хэлэлцүүлэн санал авах арга хэмжээг зохион байгуулах, мөн дээрх хуулиуд батлагдсаны дараа орон нутаг, дүүрэг, ажил олгогч даатгуулагч нарт сургалт зохион байгуулахад 100.0 сая төгрөг шаардагдахаар байна.

Мөн Гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах, эрх ашгийг хамгаалах зорилгоор Монгол Улсад иргэд олноор оршин суудаг улстай нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийг байгуулах шаардлага үүссэн. Одоогоор Монгол Улсын Засгийн газраас Оросын Холбооны Улс, Австралийн Холбооны Улстай нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн төслийг боловсруулан хамтран ажиллаж байна.

Олон улсын гэрээний тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцээрийн төслийг боловсруулахдаа хоёр тал хамтран боловсруулж, хэлэлцээ хийж, эцэслэн тохиролцдог. Үүний дагуу 2025 оны 9 дүгээр сард Австралийн Холбооны Улсын шинжээчдийн баг Монгол Улсад ирж хэлэлцээрийн төсөлд хамтран ажиллах бөгөөд, харин

2026 онд Монгол Улсын шинжээчдийн баг Австралийн Холбооны Улс, Оросын Холбооны Улсад очиж ажиллах тул уг зардалд 90.0 сая төгрөг шаардагдахаар байна.

Хуримтлалын сангийн үйл ажиллагааг тогтвортой байлгах, үр өгөөжийг нэмэгдүүлэх, улмаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сан бий болгоход бусад улс орнуудын сайн туршлагыг судлан, хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна. Иймд энэхүү арга хэмжээний хүрээнд Бүгд Найрамдах Казакстан Улс улсын сайн туршлагыг судлахаар 4 хүний бүрэлдэхүүнтэй баг очиж ажиллахаар төлөвлөж, 20.0 сая төгрөгийг төсөвлөв.

Хуримтлалын сангийн талаар олон улсын туршлага судлах

Улс	Хүний тоо	Нислэгийн зардал	Нийт үнэ
Казахстан Улс	4	5,000,000	20,000,000
Бүгд			**20,000,000**

Хуримтлалын сангийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийн нэгдсэн системийг шинээр бий болгох ажлын хүрээнд "Санхүүгийн, мэдээллийн технологийн төв" Улсын төсөвт үйлдвэрийн газартай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Тус мэдээллийн нэгдсэн сан бий болсноор Монгол Улсын 3.5 сая иргэний бүртгэл, мэдээлэл үүсэж, иргэдийг мэдээллээр хангах боломж бүрдэх юм. 2025 ондоо багтаан энэхүү мэдээллийн санг ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Иймд шинэ системийн талаар иргэд, олон нийтэд ойлголт мэдлэг өгөх зорилгоор гарын авлага, видео контентоор дамжуулан хүргэх ажлыг зохион байгуулахад шаардагдах 10.0 сая төгрөгийг төсөвлөсөн болно.

Хуримтлалын сангийн үйл ажиллагааны хэрэгжилт болон мэдээллийн сангийн системийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах

Үзүүлэлт	Тоо	Үнэ	Нийт үнэ
Гарын авлага	4000	1,000	4,000,000
Видео контент	2	3,000,000	6,000,000
Бүгд			**10,000,000**

№	Арга хэмжээ	Дүн /сая.төгрөгөөр/
1.	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.3 дахь хэсэгт заасан хүүгийн өгөөжийн зөрүү 2026 оны төсвийн төсөл /Сайдын багцад орлого, зарлагаар тусгана/	179,335.6
2.	Нийгмийн даатгалын багц хууль болон Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах	100.0
3.	Нийгмийн хамгааллын хэлэлцээр (Орос, Австрали)	90.0
4.	Хуримтлалын сангийн талаар олон улсын туршлага судлах	20.0
5.	Хуримтлалын сангийн үйл ажиллагааны хэрэгжилт болон мэдээллийн сангийн системийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах	10.0
Нийт дүн		**179,555.6**

---oOo---

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2025 ны 07 дугаар сарын 29-ны өдрийн 01/2505
дугаар албан бичгийн тавдугаар хавсралт

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЦАЛИН ХӨЛСИЙГ НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ 2026 ОНЫ УЛСЫН ТӨСӨВТ ТУСГАХ САНАЛ

Улаанбаатар
2025

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЦАЛИН ХӨЛСИЙГ НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ 2026 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАХ САНАЛ

1. Цалин хөлсний өнөөгийн байдал

2024 оны байдлаар улсын хэмжээнд 226.9 мянган төрийн албан хаагч ажиллаж байгаагаас 3,823 (1.7%) нь төрийн улс төрийн, 21,350 (9.4%) нь төрийн захиргааны, 49,081 (21.6%) нь төрийн тусгай, 152,641 (67.3%) нь төрийн үйлчилгээний албан хаагч байна. Нийт төрийн албан хаагчдын 51.4 хувь нь Улаанбаатар хотод, 48.6 хувь нь орон нутагт ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны 2025 оны 1-р улирлын мэдээгээр нийт ажиллагчдын дундаж цалин хөлс 2,621.9 мянган төгрөг, хувийн хэвшлийн ажиллагчдын дундаж цалин хөлс 2,661.0 мянган төгрөг, төрийн албан хаагчдын дундаж цалин хөлс 2,584.5 мянган төгрөг байна.Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр 2023-2025 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр 2023 онд хэрэгжүүлсэн арга хэмжээ

Засгийн газраас төрийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотой дараах шийдвэрийг гаргаж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлсэн. Үүнд:

- Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ нь 15 зэрэглэл тус бүрт 3-5 шатлалтай, төрийн тусгай албаны цалингийн сүлжээ нь 18 зэрэглэл тус бүрт 3-5 шатлалтай буюу нийт 153 ялгаатай цалинтай байсныг өөрчлөн төрийн захиргааны албан тушаалын 15 зэрэглэлийг 10, тусгай албаны 18 зэрэглэлийг 12 болгон нягтаршуулсан. Мөн үндсэн цалинг цалингийн шатлалын хамгийн өндрөөр нь тогтоон нэг шатлалтай болгосон.

- Төрийн захиргааны болон үйлчилгээний албанд анх ажилд орсон албан хаагч тасралтгүй 5 жил ажилласны дараагаас ажилласан жилийн нэмэгдэл авч эхэлдэг байсныг өөрчилж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг жил бүрээр бодож олгодог болсон.

- Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 20.4-т заасны дагуу нийслэл, дүүргийн төсвөөс санхүүждэг захиргааны байгууллагын төрийн захиргааны албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлсэн.

Түүнчлэн, Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дунджаар 40 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Уг арга хэмжээний хүрээнд:

Төрийн захиргааны албан хаагчдын болон шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, биеийн тамир, спортын салбарын төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээг 1.0 сая төгрөгт хүргэсэн. Мөн төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэг бүхий нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 750.0 мянган төгрөг болсон. Энэхүү арга хэмжээний үр

дүнд шинжлэх ухааны салбарын албан хаагчдын үндсэн цалин дунджаар 47.0 хувиар, эрүүл мэндийн салбарын албан хаагчдын үндсэн цалин дунджаар 52.0 хувиар, бага, дунд боловсролын албан хаагчдын үндсэн цалин дунджаар 30.0 хувиар, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын албан хаагчдын үндсэн цалин дунджаар 51.0 хувиар, соёл, урлагийн салбарын албан хаагчдын үндсэн цалин дунджаар 64.0 хувиар, биеийн тамир, спортын салбарын албан хаагчдын үндсэн цалин дунджаар 58.0 хувиар тус тус нэмэгдлээ. Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин 26.0-31.0 хувиар нэмэгдсэн (2023 оны 1 дүгээр сарын 01-нээс 8 хувиар нэмэгдсэн).

Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр 2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээ

Төрийн албан хаагчдын үндсэн цалинг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зарчмыг баримтлан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүллээ. Мөн хөдөөгийн суманд ажиллаж байгаа 51.8 мянган төрийн албан хаагчид үндсэн цалингийн 40 хувь, харин аймгийн төвийн сум болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа 53.4 мянган төрийн албан хаагчид сар бүр үндсэн цалингийн 20 хувиар тус тус тооцож орон нутгийн нэмэгдлийг нийт 105.2 мянган төрийн албан хаагчид олгохоор болсон. Уг арга хэмжээний үр дүнд төрийн захиргааны болон төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээ 1.1 сая төгрөг (Суманд 1,540.0 мянган төгрөг, аймгийн төвийн сум болон алслагдсан гурван дүүрэгт 1,320,0 мянган төгрөг), төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээ 900.0 мянган төгрөг (Суманд 1,260.0 мянган төгрөг, аймгийн төвийн сум болон алслагдсан гурван дүүрэгт 1,080.0 мянган төгрөг) болсон.

Мөн 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн урамшууллыг авч эхэлсэн.

Түүнчлэн тодорхой салбарын албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр анхаарч төрийн нийтлэг үйлчилгээний албан тушаалд хамаарах архив, цаг уур, лаборатори зэрэг байгууллагын 7311 албан хаагчийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс ажлын онцлог, нөхцөлөөс хамааруулан төрийн мэргэжлийн үйлчилгээний албан тушаалд шилжүүлсэн.

Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр 2025 онд хэрэгжүүлсэн арга хэмжээ

Монгол Улсын 2025 оны улсын төсөвт тусгасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчдын үндсэн цалинг 6 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Уг арга хэмжээний үр дүнд төрийн захиргааны болон төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 1,166.0 мянган төгрөг, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээ 954.0 мянган төгрөг болсон. Дээр дурдсанаар төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх арга хэмжээнд 2025 онд 424.4 тэрбум орчим төгрөг нэмж шаардагдахаар төсөвлөсөн.

2. Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр 2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтод "Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг нэгдсэн зарчим, бодлого, арга зүйгээр шинэчлэн тодорхойлох", "Төрийн албан хаагчийн нэр хүндийг дээшлүүлж, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах зохистой тогтолцоог төлөвшүүлэх" гэж, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.7-д "Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлнэ." гэж тус тус тусгагдсан.

Уг зорилт арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зарчмыг баримтлан 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг 8 хувиар[1] нэмэгдүүлэхэд 2026 онд 560.0 тэрбум төгрөг нэмж шаардагдахаар байна.

Мөн төрийн захиргааны албан хаагчдын цалинг нэг сүлжээнд нэгтгэн тогтооход 78.6 тэрбум төгрөг, зарим албан тушаалын ангилал, зэрэглэлийг оновчтой болгоход 15.3 тэрбум төгрөг тус тус нэмж шаардагдахаар тооцлоо.

Дээрх байдлаар төрийн албан хаагчдын үндсэн цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, ангилал зэрэглэл, цалингийн сүлжээг оновчтой болгох арга хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхэд 2026 онд нийт 653.9 тэрбум төгрөг нэмж шаардагдахаар байна.

Хүснэгт 1. Төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2026 онд нэмэгдүүлэх ангилал, зэрэглэлийг оновчтой болгох хүрээнд шаардагдах төсвийн тооцоолол

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрагдах хүний тоо	Нэмж шаардагдах төсөв /тэрбум.төг/
1	Төрийн албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлэн тогтоох /8 хувь/	226,500	560.0
2	Зарим төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэгтгэн тогтоох	5,250	78.6
3	Зарим төрийн захиргааны албан хаагчдын ангилал, зэрэглэлийг оновчтой болгох	6,296	15.3
	Нийт		**653.9**

---o0o---

[1] 2025 оны 5 дугаар сарын байдлаар инфляцийн түвшин 8.3 хувь байна. УСХ-ны 2025 оны 5 сарын мэдээ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайдын 2025 ны 07 дугаар
сарын 29-ны өдрийн 01/2505 дугаар
албан бичгийн зургаадугаар хавсралт

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН САНАЛ ДАГАХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах тайлбар, хэсэг нэмсүгэй.

1/ 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгийн тайлбар:

"Тайлбар: Энэ хэсэгт заасан төрийн албанд ажилласан хугацаанд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн тайлбарт заасан тэтгэвэр тогтоолгох нас хүртэл төрийн албанд ажилласан хугацааг оруулан тооцно."

2/ 60 дугаар зүйлийн 60.4 дэх хэсэг:

"60.4. Төрийн албанд нийт 20 ба түүнээс дээш жил ажилласан төрийн албан хаагч хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш алдсан эсхүл ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барсан тохиолдолд энэ хуулийн 60.1-д заасан нэг удаагийн буцалтгүй тусламж авах эрх үүсээгүй бол 6 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг түүний ар гэрт нь олгоно. "

2 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.13 дахь хэсгийн "цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг" гэсний дараа "Засгийн газрын саналыг үндэслэн" гэж, 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгийн "Төрийн улс төрийн албан хаагчаас бусад" гэсний өмнө "Төрийн албанд нийт 5 жил, үүнээс сүүлийн 3 жил төрийн албанд тасралтгүй ажилласан" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.9 дэх хэсгийн "цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг" гэснийг "цалингийн хэмжээг" гэж, мөн хуулийн 57 дугаар зүйлийн 57.10 дах хэсгийн "цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрт" гэснийг "цалингийн хэмжээнд", 57.13 дахь хэсгийн "цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг" гэснийг "цалингийн хэмжээг" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

Төрийн албаны тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

2024 оны байдлаар улсын хэмжээнд 226.9 мянган төрийн албан хаагч ажиллаж байгаагаас 3,823 (1.7%) нь төрийн улс төрийн, 21,350 (9.4%) нь төрийн захиргааны, 49,081 (21.6%) нь төрийн тусгай, 152,641 (67.3%) нь төрийн үйлчилгээний албан хаагч байна. Нийт төрийн албан хаагчдын 51.4 хувь нь Улаанбаатар хотод, 48.6 хувь нь орон нутагт ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, адил албан тушаалд ижил цалин хөлс олгох зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаа.

Нэг. Төрийн албан хаагчид буцалтгүй тусламж олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу **төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж болон а**лбан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд 60 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг түүний ар гэрт нь олгож байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг баталсан. Төрийн албан хаагчдыг төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэшсэн байх зарчмыг хангах зорилгоор төрийн албанд нийт 5 жил, үүнээс сүүлийн 3 жил төрийн албанд тасралтгүй ажилласан төрийн албан хаагчид энэхүү нэг удаагийн буцалтгүй тусламж олгох нөхцөлийг тус журамд тусгасан.

Иргэний нэхэмжлэлийн дагуу Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүх хуралдааны 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 35 дугаар тогтоолоор тус журмын 1.2 дахь заалтыг дахин шинэ акт гаргах хүртэл 3 сарын хугацаатай түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн. Уг Улсын дээд шүүхийн тогтоолын дагуу дээрх журмын 2.1-д заасан төрийн албанд нийт 5 жил, үүнээс сүүлийн 3 жил төрийн албанд тасралтгүй ажилласан төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж авах эрх үүсэх шалгуурыг хүчингүй болгосон.

Гэвч төрийн албан хаагчдыг төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэшсэн байх зарчмыг хангах зорилгоор төрийн албанд нийт 5 жил, үүнээс сүүлийн 3 жил төрийн албанд тасралтгүй ажилласан төрийн албан хаагчид энэхүү нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгохоор хуулийн төсөлд тусгалаа. Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан тэтгэвэр тогтоолгох насанд хүртэл төрийн албанд ажилласан хугацааг дээрх өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламж олгох хугацаанд оруулан тооцохоор тусгалаа.

2024 онд 6473 төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад нь 204.9 тэрбум төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон байна. 2025 онд 7312 төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад 269.3 тэрбум төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгохоор Монгол Улсын 2025 оны төсөвт тусгасан.

Төрийн албанд 10-аас дээш жил ажиллаж байгаа албан хаагчдын гол хөшүүрэг нь энэхүү 36 сарын цалинтай тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламж болж байгаа ч төрийн албанд тогтвор сууршилтай, урт хугацаанд ажилласан зарим албан хаагчид ердийн өвчин, ахуйн ослын улмаас уг тэтгэмжээ авч чадалгүй нас барах тохиолдлууд гарч байна.

Иймд төрийн албанд нийт 20 ба түүнээс дээш жил ажилласан төрийн албан хаагч хөдөлмөрийн чадвараа алдах эсхүл ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барсан тохиолдолд 6 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг түүний ар гэрт нь олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Хоёр. Албан тушаалын цалинг итгэлцүүрээр бус цалингийн хэмжээгээр тогтоох талаар

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.9-д заасны дагуу төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтоохоор заасан.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын Ерөнхий прокурор, түүний орлогч, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Төрийн аудитын байгууллагын дарга, дэд даргаас бусад төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг Улсын Их Хурлын 2019 оны 63 дугаар тогтоолоор батлсан бөгөөд тус тогтоолд яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалын сарын цалингийн хамгийн өндөр шатлалыг тус цалингийн итгэлцүүрийн суурь байхаар оруулсан.

Гэвч Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн хуралдаанаар Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын даргын зөвлөх, Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд, дэд дарга болон Улсын Их Хурлын Тамгын газрын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг Улсын Их Хурал өөрөө тогтоохоор болсон бөгөөд тус хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын 2020 оны 40 дүгээр тогтоолоор "Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүний цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр"-ийг баталсан.

Дээрх хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбоотойгоор төрийн өндөр албан тушаалын адил зэрэг зиндаанд байгаа албан тушаалтнууд харилцан адилгүй цалин хөлс авч байна. Тухайлбал ТӨ-V зэрэг зиндаанд хамаардаг Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр 2.7 байхад ТӨ-II зэрэг зиндаанд хамаардаг Ерөнхий сайдын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр 2.02, Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Шадар сайдын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр 1.55 гэх мэт байна.

Иймд дээрх байдлаар адил ангилал, зэрэглэл, зэрэг зиндаанд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээг итгэлцүүрээр, ялгаатай байдлаар тогтоож байгаа нь адил албан тушаалд ижил цалин хөлс олгох зарчмыг алдагдуулж байгаа тул албан тушаалын цалингийн хэмжээг итгэлцүүрээр тогтоодог байдлыг өөрчилж, албан тушаалын цалинг мөнгөн дүнгээр тогтоохоор хуулийн төсөлд тусгалаа.

---o0o---

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ОРОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛАЛТ

Одоо байгаа	Шинэ заалт
57.9.Энэ хуулийн 57.13-т зааснаас бусад Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны **цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг** Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно. */Энэ хэсэгт 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*	57.9.Энэ хуулийн 57.13-т зааснаас бусад Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны **цалингийн хэмжээг** Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.
57.10.Энэ хуулийн 57.9-д заасан албан тушаалын **цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрт** Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд, дэд дарга, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүн хамаарахгүй. */Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./* */Энэ хэсэгт 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*	57.10.Энэ хуулийн 57.9-д заасан албан тушаалын **цалингийн хэмжээнд** Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, ~~Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд, дэд дарга, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүн~~ хамаарахгүй.
57.13.Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын даргын зөвлөх, Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд, дэд дарга, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүн, Улсын Их Хурлын даргын ажлын албаны ажилтан, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслах, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны дарга, ажилтан болон Улсын Их Хурлын Тамгын газрын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын **цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг Улсын Их Хурал өөрөө тогтооно.** */Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./* */Энэ хэсэгт 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./* */Энэ хэсгийг 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./*	57.13.Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын даргын зөвлөх, Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд, дэд дарга, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүн, Улсын Их Хурлын даргын ажлын албаны ажилтан, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслах, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны дарга, ажилтан болон Улсын Их Хурлын Тамгын газрын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын ~~цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг~~ **цалингийн хэмжээг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал өөрөө тогтооно.**
60.1.Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн	60.1. Төрийн албанд нийт 5 жил, үүнээс сүүлийн 3 жил төрийн албанд тасралтгүй ажилласан төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас

цалингийн дунджаас хэтрэхгүй байна. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.	ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. Тайлбар: Энэ хэсэгт заасан төрийн албанд ажилласан хугацаанд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн тайлбарт заасан тэтгэвэр тогтоолгох нас хүртэл төрийн албанд ажилласан хугацааг оруулан тооцно.
	60.4. Төрийн албанд нийт 20 ба түүнээс дээш жил ажилласан төрийн албан хаагч хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан эсхүл ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барсан тохиолдолд энэ хуулийн 60.1-д заасан нэг удаагийн буцалтгүй тусламж авах эрх үүсээгүй бол 6 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг түүний ар гэрт нь олгоно.

төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны .... дугаар
сарын ...ний өдөр
хот

Дугаар ....

Улаанбаатар

Нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтын төлөө мэдлэг боловсрол, бие сэтгэл, хүч чадлаа дайчлан гавьяа байгуулж Монгол Улсын баатар, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Төрийн эрхэм дээд цол хүртсэн ахмад настанд насны эрэмбээр тооцож 80-аас дээш өндөр настанд 50.0 сая төгрөг, эмэгтэй 55-79, эрэгтэй 60-79 хүртэлх насны ахмад настанд 30.0 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

Хоёр. Монгол Улсын баатар, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, ахмад настны нэг удаагийн буцалтгүй тусламжийг 2026 онд багтаан олгох арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т чиглэл болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН

төсөл

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны .... дугаар
сарын ...ний өдөр
хот

Дугаар ....

Улаанбаатар

Сэтгэцийн эмгэгтэй хүний төрөлжсөн
асрамжийн газар байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Төсвийн тухай хуулийн 10.1.10, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 24 дүгээр зүйлийн 24.1, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8, Нийгмийн халамжийн тухай хуулийн 8.2.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Сэтгэцийн эмгэгтэй хүний төрөлжсөн асрамжийн газрыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэд байгуулсугай.

2.Сэтгэцийн эмгэгтэй хүний төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийн хоол, хувцасны зардлыг норматив дагуу Нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакирт даалгасугай.

3.Сэтгэцийн эмгэгтэй хүний төрөлжсөн асрамжийн газрыг байгуулах, бүтэц, чиг үүргийг хууль тогтоомжид нийцүүлэн одоо байгаа орон тоонд үндэслэн баталж нэгдсэн удирдлагаар хангах, урсгал зардал болон асруулагчийн эм, хэрэгслийн бусад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнд үүрэг болгосугай.

4. Сэтгэцийн эмгэгтэй хүний төрөлжсөн асрамжийн газрын барилга байгууламжийг барих, зураг төсвийг гаргах, шаардагдах зардлыг 2026 оны төсөвт тусгахыг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасуй.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

Сэтгэцийн архаг өвчтэй, байнгын асаргаа шаардлагатай өвчтөнд зориулж анх БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1974 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн "Хөдөлмөр эмчилгээний газар байгуулах" 538 тоот тогтоолын дагуу Эрүүлийг хамгаалах яамны харьяанд 300 ортой Сэтгэл мэдрэлийн архаг өвчтөний асрамжийн газрыг байгуулж байжээ.

Эрүүл мэндийн тухай хуулийн 20.1, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7.3, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 12.1.6 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2003 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн "Бүтцийн өөрчлөлтийн тухай" 94/158 тоот хамтарсан тушаалаар Мааньт дахь "Сэтгэцийн өвчтөний хөдөлмөр эмчилгээ, асрамжийн газар"-ыг татан буулгаж Сэтгэцийн эмгэгийн клиникийн эмнэлэгтэй нэгтгэж зохион байгуулсан.

2006 онд Сэтгэц Наркологийн төвийг Сэтгэцийн клиникийн эмнэлэгтэй нэгтгэж одоогийн Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв болж өргөжсөн бөгөөд үүнээс хойш тус төв нь асрамжийн газрын үйл ажиллагааг давхар явуулж байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 2024 оны байдлаар сэтгэцийн архаг өвчтэй, байнгын асаргаа шаардлагатай, урт хугацааны эмчилгээтэй 1-36 жил хэвтэн эмчлүүлж байгаа 244 эмчлүүлэгч байгаа нь тус төвийн хэвтүүлэн эмчлүүлэх нийт орны 44.3 хувийг эзэлж байгаа бөгөөд зардлыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Эрүүл мэндийн сайдын багцын төсвөөс санхүүжүүлж байна.[1]

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд сэтгэцийн эмгэгтэй хүнд тусламж, үйлчилгээ үзүүлэх харилцааг хуульчилсан бөгөөд уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан тусламж, үйлчилгээний төрөлд сэтгэцийн эмгэгтэй хүний асрамжийн үйлчилгээг тусгасан. Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт "Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх төв байгууллага нь тусгай харуул хамгааллалт бүхий обьектод хамаарна" мөн хуулийн 13 дүгээр зүйлийн 13.1 дэх хэсэгт "Нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэгтэй хүнд шаардлагатай тохиолдолд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн тусгаарлах болон номхотгох аргыг хэрэглэх бөгөөд энэ аргын жагсаалт, тэдгээрийг хэрэглэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална" гэж тус тус заасан байна.

Гэсэн хэдий ч сэтгэцийн өвчтэй иргэнийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, аймгуудын салбар зөвлөлөөс сэтгэцийн өвчтэй хүнийг "одоогоор сэтгэцийн өөрчлөлтгүй болно" гэж тодорхойлоод улсын асрамжийн газруудад илгээх тохиолдол сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Үүнээс шалтгаалан хурц хэлбэрийн сэтгэцийн өвчтэй асруулагч нь асрамжийн газрын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, бусад асруулагчийг хэл амаар доромжилж, зодох, өрөөний тавилга эвдэх, бүх хувцсаа тайчиж өрөө тасалгаа, коридороор явах, тэргэнцэртэй хүний түлхэж унагаах зэрэг зүй бус үйлдэл гаргаж асруулагч болон албан хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсч байгаа талаар тус яаманд асрамжийн газруудаас бичиг ирэх болсон. Тухайлбал, Дорноговь аймгийн Ахмад настны асрамжийн газар 2025 оны 6 дугаар сарын 19-ны өдөр сэтгэцийн

---

[1] ГБХНХЯ-д ЭМДҮЗ-өөс 2025.01.07-ны өдрийн ирүүлсэн "Асуудал шийдвэрлүүлэх тухай" 04 дүгээр албан бичгийн хавсралт

өвчтэй асруулагч Б нь өөр өрөөнд байсан асруулагчийн өрөөнд шөнө орж, түлхэж унагаан амь насыг нь хохироосон ноцтой хэрэг гарсан байна.

Сэтгэцийн эмгэгтэй хүнийг төрөлжсөн асрамжийн газарт үйлчлүүлэхэд өөртөө болон бусдад гэм хор учруулах эрсдэлтэй байдаг тул бие даасан хамгаалалт, тусгай эмчилгээ зайлшгүй шаардлагатай боловч улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 11 асрамжийн газарт сэтгэцийн хурц хэлбэрийн оношгой, тогтмол сэтгэцийн эм уух шаардлагатай 69 асруулагч асруулж байна.

Сэтгэцийн өвчин, оюуны хөгжлийн бэрхшээл нь ялгаатай бөгөөд даун, аутизм, уналт таталт, тархины саажилт зэрэг оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрамжийн газруудад бусад асруулагчийн хамт асрах боломжтой, ийм бэрхшээлтэй 100 гаруй асруулагч асрамжийн газруудад байгаа бөгөөд харин дээрх 69 хүн нь сэтгэцийн өвчтэй тул бусад асруулагчийн хамт асрах боломжгүй байна.

Тус яаманд УИХ-ын НББХ болон ЭМДҮЗ-өөс сэтгэцийн өвчтэй хүний асрамжийн газрыг анхаарах, санхүүжилтийг Нийгмийн халамжийн сангаас зарцуулах шаардлагатай байгаа тухай албан бичгүүд 2025 онд ирүүлж байсан. Нийгмийн халамжийн сангаас төрөлжсөн асрамжийн газрын асруулагчийн хоол, хувцас зэргийн зардлыг батлагдсан нормативын дагуу олгодог бөгөөд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлж байгаа асруулагчийн зардлыг санхүүжүүлэх боломжгүй байгаа юм.

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн дагуу сэтгэцийн эмгэгтэй хүнд мэргэжлийн эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүлж, тусгай харуул хамгаалалттай обьект байхаар заасан бөгөөд одоогийн төрөлжсөн асрамжийн газруудад мэргэжлийн эмч, ажилтан ажиллуулахад удирдлага зохион байгуулалтыг хангах чадавх байхгүйгээс гадна эмчилгээ үйлчилгээ явуулах эрх олгох асуудал Эрүүл мэндийн тухай болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд байхгүй.

Мөн сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хангах, хоол, хувцас, ахуйн хэрэглээний чанарыг сайжруулах нөгөө талаас асрамжийн газар асруулж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах асуудал өнөөдөр нэн тэргүүнд тулгамдаж байна.

Төрөлжсөн асрамжийн газрын асруулагчийн хоол, хувцасны зардлын нормативын дагуу Нийгмийн халамжийн сангаас 313 асруулагчид жилд 2.4 тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд зардлыг 2026 оны төсөвт тусгах шаардлагатай. Мөн Сэтгэцийн эмгэгтэй хүний төрөлжсөн асрамжийн газар байгуулснаар асруулагчийн сар бүрийн тэтгэврийн 30 хувийг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу асрамжийн газрын үйл ажиллагаа, асруулагчийн хөгжлийг дэмжсэн арга хэмжээнд зарцуулах боломжтой болно.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ